

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.03.30

Булган сум

Зорилго: Тус газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Цагдаагийн албаны тухай хууль, үүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, эрх зүйн актуудыг судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, ил тод нээлттэй байх, олон нийтийн итгэлийг хүлээж, иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан орчин үеийн техник технологи мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, цагдаагийн албаны үндсэн зарчмыг баримтлан алба хаагч ажилтныг сургаж бэлтгэх, чадварыг дээшлүүлэх, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах ажлыг нийт бие бүрэлдэхүүн, олон нийтийн дэмжлэг туслалцаанд түшиглэн хэрэгжүүлэн ажилласан.

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар

-Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр: /хөтөлбөр төлөвлөгөө холбогдох бусад баримт бичгийн хэрэгжилтийг гарган хүргүүлсэн байдал/

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн Б\01 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн газраас Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Захиргааны хэм хэмжээний акт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёр дахь хөтөлбөр, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний 2 дахь хөтөлбөр, Гэрч хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөр, Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2019/, 2018 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019/, Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх,

тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүний эрхийн үндэсний комисс, ЦЕГ-ын даргын хооронд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/46-р тушаалыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар, өгсөн үүрэг, ажлын чиглэл, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, баталсан хөтөлбөр, төлөвлөгөө, өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, тушаал шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтүүдийг заасан хугацаанд тухай бүр нь хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 187 тоот тогтоолоор баталсан Ерөнхий менежер, нэгжийн менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын дагуу Цагдаагийн газрын даргатай бүх шатны дарга нар 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, тасгууд үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавин сар бүр ажлаа дүнгүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 48, 2009 оны 12 дугаар сарын 15-ны 188-р тогтоолоор батлагдсан заавар, журмын дагуу цагдаагийн газрын алба хаагч нартай тасгийн дарга нар 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, 2018 онд хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг нь батлан, хэрэгжилтэнд нь хяналт тавин сар бүр ажлыг нь дүгнэн үр дүнгээр нь цалинг олгон ажилласан.

-Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаалын тоо

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурал нийт 3 удаа хуралдаж удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 9, хүний нөөцийн чиглэлээр 22 асуудал, сахилга хуриуцлагын чиглэлээр 2 асуудлаар сонсгол мэдээлэл оруулан хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Цагдаагийн газрын даргаас 2018 оны 01 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагааны чиглэлээр 24 тушаал, боловсон хүчний чиглэлээр 40 тушаал гарган биелэлт үр дүнг тооцон тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

-Хүний нөөцийн талаар

Тус цагдаагийн газарт 2018 оны 01 дүгээр байдлаар 2 алба хаагч шинээр томилогдон ажиллаж байна. Цагдаагийн газрын даргын тушаалаар шинээр томилогдсон алба хаагч нарт сургагч багш томилон дасан зохицох хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан ажиллаж хэвшээд байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх журам /код-944/”-ын дагуу богино

хугацаанд ажилд нь сургаж, дадлагажуулан биелэлт үр дүнг тооцож ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. Дадлагажих багшийг ахлах албан тушаалтай алба хаагч нараас дээш албан тушаалтай алба хаагч нарыг тушаалаар томилон ажиллаж байна. Шинээр томилогдон ажиллаж байгаа 2 алба хаагч нарыг ЦЕГ-ын сургалт дадлагын төвд сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн газрын даргын тушаалаар Шинээр томилогдсон алба хаагч нарт халамжлан хүмүүжүүлэгч багш томилж, үр дүнгийн гэрээ байгуулж биелэлт үр дүнг тооцон, тухайн алба хаагч сахилгын зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хамтын хариуцлага тооцон ажилласан.

Сахилгын зөрчил дутагдал гаргасан алба хаагч нарт дахин зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр баталгаа авч, холбогдох хууль, дүрэм, журмуудыг өөрөөр нь судлуулах, үр дүнг тооцох, хариуцсан алба хаагч нартаа бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулахыг холбогдох тасгийн дарга нарт тушаалаар үүрэг болгон өгч ажиллаж байна.

Шинээр томилогдсон 2 алба хаагч нараар баталгаа бичүүлэн авч хувийн хэрэгт нь хавсарган ажиллаж байна. Одоогийн байдлаар шинээр томилогдсон алба хаагч нараас сахилгын зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй болно.

Ажлын байрны тодорхойлолтонд заасан үндсэн үүрэгт ажилдаа идэвхи зүтгэл үр, бүтээл гарган ажилласанг нь үнэлж дараах алба хаагч нарыг шагнаж урамшуулсан байна. Үүнд:

-Төрийн шагнал

1.“Цэргийн хүндэт” тэмдэгээр Хангал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Батбилэг

Тус цагдаагийн газар нь 136 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас одоогийн байдлаар нийт 127 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Хүний нөөцийн нэгдсэн санд одоогийн байдлаар 127 алба хаагчийн мэдээллийг шивж ажилласан. Шинээр ажилд орсон нийт 2 алба хаагчийн мэдээллийг санд шивж ажилласан.


Тус газрын нийт 64 ахлагчийн хувийн хэрэгт тогтмол баяжилт хийн ажиллаж байна. Офицер алба хаагчдын хувийн хэргийн баяжилтийг Хүний нөөц, сургалтын хэлтэст тухай бүр нь албан тоотой хүргүүлэн ажиллаж байна. Бусад алба хаагч нарын хувийн хэрэгт тогтмол баяжилт хийн ажилласан.

Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нийт 30 алба хаагчаар бөглүүлэн алдаа дутагдал гаргалгүй Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажилласан. Офицер албан тушаалд шинээр томилогдсон болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн 8 алба хаагчид Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг ХАСХОМ-ыг 30 хоногт багтаан бөглүүлэн баталгааны маягтыг хэвлэн авч гарын үсэг зуруулсан. Одоогийн байдлаар хугацаа хоцорч Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг ХАСХОМ-ыг бөглүүлсэн алба хаагч байхгүй болно.

-Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Тус Цагдаагийн газраас алба хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн талаар нэгдсэн судалгаа хийж, үйл ажиллагааны тайлантай танилцсаны үндсэн дээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1.2018 онд тус Цагдаагийн газрын 80 жилийн ой тохиох учир алба хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор “Булган цагдаа 80-Бүтээлч ажил” аяныг эхлүүлсэнийг эрчимжүүлж 2018 оны 03-р сарын 27-ны өдөр Цагдаагийн газрын даргын А/21 дүгээр тушаал гарган Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, мөн даргын А/20, А/22, А/23, А/24 дугаар тушаалуудаар төлөвлөгөөний дагуу ажлын дэд хэсгүүдийг байгуулж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар шинэлэг санаа, арга барил, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах, иргэд олон нийттэй хамтран ажиллах, тэдний дэмжлэг тусалцааг авах, идэвхи санаачлагыг өрнүүлэх, байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа, ажлын ололт амжилт, үр дүнгийн талаар олон нийтэд сурталчилах, алба хаагчдын сахилга ёс зүйн байдлыг дээшлүүлэх чиглэлүүдээр тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн 2018 оны 06-р сарын 31-ний өдөр нэгтгэн дүгнэхээр ажиллаж байна.



Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/57 тоот “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага батлах тухай” тушаалаар батлагдсан стандарт нөхцлийг хангасан өрөөг 2018 оны 1-р сарын 19-ний өдөр дуусгаж, ашиглалтанд хүлээн авснаар шинэчлэн батлагдсан хуулийн хэрэгжилт хангагдсан.



Мэдүүлэг авах өрөөнд 2 ширхэг компьютер, 4 ширхэг хяналтын камер, 2 ширхэг принтер, 2 ширхэг тог баригч, камерын төхөөрөмжүүдийг угсарч хэвийн ажиллагаанд оруулсан.

Эд мөрийн баримт, граж, склад зэргийг хянах 3 ширхэг камер суурилуулан ЖША-ны хяналтын дэлгэцэнд хяналтыг холбож ажилласан.





Эрүүгийн цагдаагийн тасгийн гадна хаалгыг тусгай картаар онгойх зориулалт бүхий соронзон түгжээг байрлуулсан.



Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ


Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдаж ирээгүй болно.

-Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай /гэрээ, санамж бичиг байгуулан, хамтран ажилласан байдлын талаарх мэдээлэл/

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2 хүүхдийг цаашид суралцах нөхцөлөөр хангах зорилгоор Хутаг-Өндөр суманд байрлах Бялхам үндэс төрийн бус байгууллагыг түшиглэн ерөнхий боловсролын сургуульд суралцуулсан.

Булган аймаг дахь Гэр бүлийн радио-106.5 хамтран “Сэтгэлийн үр” нэг цагийн шууд нэвтрүүлгээр эрсдлээс хамтдаа сэргийлье нэг сарын аяны талаарх мэдээлэл, Гэр бүлийн харилцаа, Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн хүлээх үүрэг сэдвүүдээр 3 удаагийн мэдээлэл бэлтгэн иргэдэд сурталчилж ажилласан.

2018 оны 1-р сарыг “Эрсдлээс хамтдаа сэргийлье” аян болгон зохион байгуулж аяны хүрээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Онцгой байдлын газар, Улаан загалмайн нийгэмлэг, Иргэний зөвлөлтэй хамтран “Охид-Хөвгүүд” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан Ерөнхий боловсролын сургуулийн 374 сурагчийг эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 468 сурагчдад нөхөн үржихүй, эрүүл мэндийн чиглэлээр сургалт мэдээлэл өгсөн. Мөн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран зорилтод бүлгийн 6 өрхийн 24 хүүхэд, насанд хүргэгчдийг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулан, дулаан хувцсаар хангаж ажилласан.



Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн 26 өргөдөлд бүртгэл хяналтын карт хөтлөн газрын удирдлагад танилцуулан, мэдээлэл судалгааны мэргэжилтэнд бүртгүүлэн холбогдох алба хаагчдад хүргүүлэн ажилласан.



Иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл гомдол мэдээллийг түргэн шуурхай бодитой шийдвэрлэхэд удирдлагын зүгээс өргөдөл гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн явц байдлын талаар судалгаа гаргуулан нийт алба хаагчдад долоо хоног бүрийн Баасан гараг бүр танилцуулж хариуцсан алба хаагчдад хугацаатай үүрэг чиглэл өгч үр дүнг тооцож ажилласан.

Тус газар нь ЦЕГ-с хэрэгжүүлж байгаа мэдээлэл холбоо технологийн бодлогын хүрээнд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол мэдээлэл бүрийг мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаатай холбогдуулан алба хаагчдын өргөдөл гомдол мэдээллийг шийдвэрлэж буй байдалд онлайн хэлбэрээр хяналт тавьж ажиллаж байна. Алба хаагчдын зүгээс өргөдөл гомдол мэдээллийг дарагдуулдаг байдлыг арилгах чиглэлээр ёс журмын эргүүл ажиллуулах, дуудлага мэдээлэл хүлээн авах утсанд бичлэг хийх төхөөрөмж суурьлуулан тухай бүр хяналт тавин, сумдын алба хаагчдын ажлыг улирал бүр шалган зааварчилж, зөвлөлийн хуралд мэдээллийг нь оруулж байгаа ажиллагаа нөлөөлж байгаагаас гадна иргэд цагдаагийн байгууллагад итгэх итгэл нэмэгдэх, аливаа нэг асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлүүлэхийн ач холбогдолыг ойлгосон зэрэгтэй холбож дүгнэж болохоор байна.

Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх ажлын төлөвлөгөөнд иргэд байгууллага аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлж байгаа өргөдөл гомдол, түүний шийдвэрлэлт, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл судалгааны мэргэжилтэн сар бүр мэдээлэл бэлтгэн оруулж хэлэлцүүлэн, шийдвэрлэлт удааширч байгаа гомдол мэдээлэл бүрийг хариуцан шалгаж байгаа алба хаагч бүрээс шалтгааныг нь тодруулж нийт 3 алба хаагчдад үүрэг чиглэл өгч, зөрчлийг засуулсан.

Цагдаагийн алба хаагч, гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд хариу өгч байгаа байдлыг хянах зорилгоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гаргасан шийдвэр болгонд хариу өгөх хуудас бичиж, мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн шийдвэр бүрт дугаар олгон бүртгэлээр хяналт тавин, төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтыг явуулан ажилласан.

-Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ

Булган суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдож хорио цээрийн постонд 5 ширхэг туузан гэрэл /Маяк/ БНХАУ-ын Эрээн хотоос худалдан авч суурь хийж постуудад байршуулан нь эрсдлээс урьдчилан сэргийлэх шинэлэг ажил болсон.

Нарны энеригээр цэнэглэгддэг суурин туузан гэрэл /маяк/-нд хөл гагнаж, ажиллагааг шалгаж Зоон даваа, Хөх монгол, Шунхлай уулзвар, Хужир толгой, 18-ын дөрөлж зэрэг 5 постонд байрлуулж ажиллаа.

Хогийн жалга, Өлийн даваа, Дашмэргэний пост зэрэг 3 постонд байрлуулж нарны элементыг нар руу харуулж цэнэглэхэд тохиромжтойгоор суурийг эргүүлдэг байдлаар хийж гүйцэтгэсэн.



Цагдаагийн газрын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын 1 давхарын галт зэвсэг болон мөрдөн байцаагч нарын албан өрөөний цонхыг төмөр решотка хийж ажилласан.



-Судалгаа, дүн шинжилгээ хийсэн ажлын талаар

Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргаас 2018.03.05-ны өдрийн 2/98,



Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын даргаас 2018.01.19-ний өдрийн 8/150, 2018.01.22-ны өдрийн 8/167



дугаартай үүрэг ажлын чиглэл бүхий зөвлөмж ирүүлсний дагуу тус бүрт нь төлөвлөгөө гарган мэдээллийн нэгдсэн санд хандах эрх бүхий нийт алба хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус зөвлөмжийн дагуу мэдээллийн нэгдсэн санд хандалт хийх эрх бүхий алба хаагчдад мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэнгээс санд ажиллах, статистик мэдээ гарахад анхаарах асуудал, “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх журам /код 701/, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх журам /код-702”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр газрын даргын 2018.03.16-ны өдрийн 34/01-423, 424 дугаарт зөвлөмжийг хүргүүлээ.

Судалгаа хяналтын санд мэдээллийг бүрэн оруулах зорилгоор төвийн болон сумдын тасгийн алба хаагчдаас мэдээлэл оруулах хуваарь гарган хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан. Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд сургалтын цагаар “Мэдээллийн нэгдсэн санд ажиллах аргачлал” сэдвээр сургалт мэдээлэл хийсэн.

Мэдээллийн нэгдсэн санд гэмт хэргийн **459**, захиргааны зөрчлийн **2619**, захиргааны тоо бүртгэлийн **132**, өргөдөл гомдлын **612**, шийдвэрлэлтийн **724**, хайлт лавлагааны **475** мэдээлэлд хандалт хийж ажиллалаа.

Тус газарт мэдээллийн нэгдсэн санд ажиллах эрх бүхий **112** алба хаагч ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар санд нийт **101** алба хаагч хандалт хийсэн байна.

Мэдээллийн нэгдсэн санд ажиллах эрх бүхий нийт алба хаагчдаас мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх, алдаа дутагдал гаргахгүй ажиллах баталгаа гаргуулан, санд алба хаагчдаас ажилласан байдлыг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон дүгнэж, алдаатай, зөрчилтэй мэдээлэл оруулсан тохиолдол бүрийг газрын даргын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх журам / код701”-ын заалтыг зөрчиж ажилласан **9** алба хаагчийн үндсэн цалинг **5-10** хүртэл хувиар хасаж тооцсон байна.

Сар бүрийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, “Хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан” сэдвээр танилцуулга бичиж, цаашид үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж, хэргийг бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

бусад /Удирдлага зохион байгуулалтын шинжтэй бүхий л арга хэмжээг тусгана/

Аймаг, сумын Засаг дарга, ИТХ, ГХУСАЗЗ, салбар зөвлөлийн хуралд тус газрын алба хаагчдаас нийт 29 удаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар танилцуулж, танилцуулганд 32 асуудал шийдвэрлүүлэхээр санал оруулсны 9 буюу 28,1 хувийг дэмжин тодорхой төсвийг шийдвэрлэж өгсөн байна. Тухайлбал: Хишиг-өндөр, Могод сумдад шинээр камер нэмж тавиулах 8,000,000 төгрөг, Баяннуур сум замын хажууд байрлуулах зурагт самбар хийлгэх 500,000 төгрөг, бусад сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг хэвлүүлэх, тэмцээн, уралдаан зохиох, автомашины сэлбэг, хяналт шалгалт, сургалтын шатахууны зардал зэрэгт 3,399,000, олон нийтийн эргүүлд сайн ажилласан байгууллагуудыг урамшуулах 450,000 төгрөг, Прокурорын газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх техник, тоног төхөөрөмж 5,000,000 төгрөг, “Булганы

мэдээ” сонинтой гэрээ байгуулах 1,392,000 төгрөгийг тус тус аймаг, сумын ГХУСА33-өөс санхүүжүүлсэн байна.

Авто зам дагуу хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа 5 постонд Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 2,700,000 төгрөг шийдвэрлүүлэн нарны гэрлээр ажиллах туузан гэрлийг хятад улсаас захиалан авчруулж байрлуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тус газраас "Олон нийтийн цагдаа нарын хувцасны зардал шийдвэрлүүлэх тухай", "Цагдаагийн газрын үйл ажиллагааны эмхэтгэл хэвлүүлэх нь", "Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зам тээврийн осол хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдэн гарч буй гэмт хэрэг, зөрчил, цаашид анхаарах асуудал" сэдвээр тус тус мэдээлэл хийж, хэлэлцүүлэн Олон нийтийн цагдаа нарын хувцасны зардал, Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны эмхэтгэл хэвлүүлэх зардлыг аймгийн Засаг даргын нөөцөөс шийдвэрлэхээр болсон.

Хутаг-өндөр сум дахь сум дундын Цагдаагийн тасгаас санаачлан "Гацуурхан" цэцэрлэг, сумын ЗДТГ-тай хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний дадал соёл эзэмшүүлэх зорилгоор цэцэрлэгийн гадна “мини дром” хийж ашиглалтанд оруулсан..

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.02.14-ний өдөр Хот тохижилт үйлчилгээний ангитай хамтарч үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 478 гэрэлтүүлэг байсныг Хот тохижилт үйлчилгээний ангиар засварлуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Булган аймгийн Цагдаагийн газраас сумдын Засаг дарга, сум дундын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нартай 2018 онд хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж, аймгийн эрүү хэв журмын нөхцөл байдал, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, анхаарах асуудлаар мэдээлэл хийж, хэсэгчилсэн урлагийн тоглолтоор мэндчилгээ дэвшүүллээ. Мөн энэ үеэр 2017 оны гурвалсан гэрээний биелэлт, үр дүнг тооцож гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутагтаа үр дүнтэй ажил зохион байгуулсан Рашаант сумын Засаг дарга Ш.Бат-эрдэнэ, Дашинчилэн сумын Засаг дарга Д.Луттөмөр, Тэшиг сумын Засаг дарга Б.Батсайхан, Хангал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Батбилэг, Дашинчилэн сумын Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Э.Энхболд нарыг Цагдаагийн газрын “Баярын бичиг”, дурсгалын зүйлээр, Бугат сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Энхтөрийг Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр, бусад сумдын Засаг дарга нарт “Талархал”, дурсгалын зүйлээр тус тус урамшуулав.

**Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах,
олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр**

Нэг. Өргөдөл гомдол мэдээллийн талаар

Тус цагдаагийн газарт иргэд байгууллага, албан тушаалтангаас 2018 оны 1-р улирлын байдлаар 284 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 325 гомдол мэдээлэл буюу 53,3 хувиар буурсан байна. Хүлээн авсан нийт гомдол мэдээллийн 99 буюу 34,8 хувь нь гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл байгаа ба үүнээс 75



буюу 75,7 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 11 буюу 11,1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.


Нийт гомдол мэдээллийн 33 буюу 11,6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан этгээд, эсхүл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон мэдээлэл, 373 буюу 23,2 хувийг танхайрсан мэдээлэл, 28 буюу 9,8 хувийг хулгайлах, 80 буюу 28,1 хувийг бусдын биед халдах, 8 буюу 2,8 хувийг хүний амь нас хохирсон мэдээлэл, 9 буюу 3,1 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гомдол мэдээлэл эзлэж байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг 5 хоногийн хугацаанд, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг ажлын 3 хоногийн хугацаанд шалгаж шийдвэрлэхээр тусгасан зэрэг өргөдөл гомдол шалгаж шийдвэрлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангаж ажиллах талаар нийт гэмт хэрэг зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад Прокурорын газартай хамтарсан сургалтыг зохион байгуулсан.

Хоёр. Гэмт хэргийн талаар:

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 3 сарын байдлаар 69 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 хэргээр буюу 12,7 хувиар буурсан.

БҮСТЗЭТХэрэг 60 бүртгэгдэн 18 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 30 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 37,7 хувиар буурсан.



Могод, Тэшиг, Баян-Агт, Хялганат, Бүрэгхангай, Бугат, Булган сумдад гэмт хэргийн гаралт урьд оны мөн үеэс өсч, Рашаант, Булган, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай, Хялганат, Сэлэнгэ, Гурванбулаг, Орхон, Хангал, Баяннуур, Сайхан сумдад өнгөрсөн оны мөн үеэс буурч, Хутаг-Өндөр суманд өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.

ХЭРГИЙН ӨНГӨӨР НЬ АВЧ ҮЗВЭЛ

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдэн 7 хэргээр буюу 7 дахин
- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 8 бүртгэгдсэн 5 хэргээр буюу 1,6 дахин
- Залилах гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 хэргээр буюу 1 дахин **өссөн**
- Хулгайлах гэмт хэрэг 18 бүртгэгдэж 11 хэргээр буюу 37,9 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 5 бүртгэгдэж 7 хэргээр буюу 58,3 хувиар
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдэж 5 хэргээр буюу 62,5 хувиар
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг бүртгэгдээгүй буюу 1 дахин
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22 бүртгэгдэж 6 хэргээр буюу 21,4 хувиар **тус тус буурсан**

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫН ТУХАЙД

-Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 165,8 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 161,6 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс хэрэг бүртгэлт мөрдөнбайцаалтын шатанд 14,2 сая төгрөгний хохиролыг нөхөн төлүүлж ажилласан. Энэ нь нийт хохирлын 8,5 хувь юм.

-Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеэс 54,5 хувиар буурсан байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 8 хүн амь насаа алдсан байна.

-Гэмт хэргийн улмаас 25 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 19, ХАБТХАЖЭГХ-ийн улмаас 5 хүн, бусад хэргийн улмаас 1 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 69 хувиар буурсан.

СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙД

-Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 21 бүртгэгдэж 2 хэргээр буюу 8,6 хувиар буурсан.

-Рашаант, Бүрэгхангай, Баян-Агт, Баяннуур, Могод, Орхон сумдад ижил түвшинд Хутаг-Өндөр, Гурванбулаг, Тэшиг, Сайхан, Булган сумдад өссөн. Сэлэнгэ, Хялганат, Хангал, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Бугат сумдад буурсан байна.

БҮЛГЭЭР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙД

-Нийт 10 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8 хэргээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСДИЙН ТАЛААР

-18 гэмт хэрэгт 26 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47 хүнээр буюу 64,3 хувиар буурсан.

Зөрчил гаргасан нийт 2203 зөрчилд 93.3 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авсан байна.

-Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 100 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 40 хүнээр буюу 28,6 хувиар буурсан байна.

-Захиргааны журмаар 26 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, торгуулсан 54 иргэн байна.

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр

Тус тасаг нь 2018 оны 01-р улиралд гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий 26 алба хаагч, жижүүрийн шуурхай алба, мэдээлэл судалгааны байцаагч нийт 40 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд эрүүгийн мөрдөгч цагдаагийн ахлах дэслэгч Т.Мөнхбат мэдээлэл судалгааны ахлах байцаагчаар, Рашаант суман дахь сум дундын тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Мөнхжаргал Хэрэг бүртгэх тасгийн даргаар дэвшин томилогдож, Могод сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Анхбаяр, эрүүгийн мөрдөгчөөр, жижүүрийн офицер, цагдаагийн ахлах дэслэгч Д.Дэлгэрмөрөн, эрүүгийн мөрдөгчөөр, хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Нямхүү тус тус ЦЕГ-ын даргын тушаалаар томилогдон ажил үүрэг гүйцэтгэн ажиллалаа.

ЦЕГ, ЭЦГ-ын даргын тушаал, албан даалгаврын хэрэгжилтийн талаар

Тус Эдийн засгийн алба нь Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2015 оны 01 тоот албан даалгавар, Эрүүгийн Цагдаагийн албаны “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгавар, Эрүүгийн Цагдаагийн газрын 03- тоот гадаадын иргэн, аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 03 тоот албан даалгавар, Гадаадын иргэнтэй харилцах журам, болон Цагдаагийн Ерөнхий газрын 2016 оны 02-р сарын 19-н өдрийн 03/09 тоот албан бичгээр ирүүлсэн “Гадаадын иргэдийг нүд үзэж тоолох” тухай ажлын чиглэл, мөн Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн 2017 оны 12-р сарын 18-ны өдрийн МН-10д/2384 тоот албан бичгээр ирүүлсэн үүргүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн хөрөнгө, бонд, гадаад, дотоодын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилт, мөнгөний урсгалыг дагуулж Гүйцэтгэх ажлын хүчийг оновчтой газар зохион байгуул гэсний дагуу орон нутгийн өмчийн алба / худалдан авах газар /, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, төрийн сангийн хэлтсүүдэд туслах хүчийг зохион байгуулж ажилласан байна. Мөн аймгийн хэмжээнд 2017 онд хийгдсэн худалдан авалт, хийгдсэн ажил, олгогдсон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд Гүйцэтгэх ажлын шугамаар хяналт тавин МУ-ын ЭХТА-ын 22.1 заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан 1 гэмт хэргийг илрүүлэн шалгалтын ажиллагааг явуулж байна.

2018 онд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулсан байна. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор аймгийн мэргэжлийн хяналтын газар, “Зэд” хантай дархан цаазат бүтээлийн нурууны хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээг байгуулж мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд ашигт малтмалын газраас 2016, 2017 онд “Цахим бүртгэлийн систем”-ээр хайгуулын тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдийн судалгааг гаргаж татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал олборлох, хайх, гэмт хэргүүдийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллаж байгаа бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн /наймаа/-нд ГА-ын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, хяналт тавьж ажиллах талаар нутаг дэвсгэр хариуцсан тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт бичгээр үүрэг өгч биелэлт үр дүнг тооцож ажиллаж байна.

Цагдаагийн Ерөнхий газрын 2018 оны 02-р сарын 01-ны өдрийн 46/658 албан бичгээр ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын зөвлөмжтэй танилцаж. Цагдаагийн газрын 2018 оны авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулж авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газрын нийт алба хаагчдад “Авлига, ашиг сонирхлын тухай ойлголт”, “авлигын эсрэг хууль, тогтоомжийн тухай ойлголт” сэдвээр 2018 оны 02-р сарын 13-ны өдөр 1 цагийн сургалтыг орж орсон сургалтын дагуу шалгалтын тест боловсруулж алба хаагчдаас шалгалт авсан байна. Авсан шалгалтын дүнг нэгтгэхэд нийт 96 алба хаагчын 62 алба хаагч 80-100

хувьтай үнэлэгдэж, 29 алба хаагч 70-80 хувь, 5 алба хаагч 60-70 хувьтай үнэлэгдсэн байна.

Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулж үр дүнг тооцож 3 алба хаагчыг шагнаж урамшуулсан байна.

ЭЦА-ны даргын 2018 оны 02-р сарын 21-ний өдрийн 01 тоот албан даалгаврынг хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган цагдаагийн газрын дагаар батлуулан холбогдох ажиллагааг хийн ажиллаж байна.

Албан даалгаврын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын танилцуулгыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж хар тамхи, Зэрлэг олс буюу каннабис ургамалын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгт Монгол улсын хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хар тамхитай тэмцэх газруудаас авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг танилцуулан аймгийн хэмжээнд ургаж байгаа Зэрлэг олс буюу каннабис ургамалын устгалд хийх ажилд байгаль хамгаалах сангаас 50.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан.

Эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар шилжүүлсэн материал:

2018 оны I улиралд тус эрүүгийн цагдаагийн тасаг нь ГА-ын шугамаар 105 мэдээ, мэдээлэл авч шалган баримтжуулан ажиллаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгасан 288,800,000 мянган төгрөгний хохиролтой, 13 холбогдогчтой 16 гэмт хэргийг илрүүлэн илрүүлэн шилжүүлснээс 4 гэмт хэргийг нөхөн илрүүлэн ажилласан байна. Тайлангийн хугацаанд ASAP сангаар эрэн сурвалжлагдаж байсан 7 этгээд, бусад аймаг хэлстээс эрэн сурвалжилж байсан 3 этгээдийг баривчилан ажилласан.

2018 оны эхний улиралд тасгийн алба хаагчдаас 212 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан 19 гэмт хэргийг мөрдөн байцаалтанд яллагдагчаар татан шилжүүлэн ажиллалаа. Хэргийг өнгөөр нь авч үзвэл хөнгөн ангилалын 166, хүнд ангилалын 32 гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан байна.

Эрэн сурвалжлах ажил “ASAP” сангийн ашиглалтын талаар

Тайлангийн хугацаанд эрэн сурвалжлах ажил, “ASAP” сан хариуцсан эрүүгийн ахлах төлөөлөгч 1 ажиллаж ASAP сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа сураггүй алга болсн хүн, хулгайд алдсан эд зүйл, тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, хэн болох нь тогтоогдоогүй цогцос, ХБ, МБ, Прокурор, Шүүх, хорих ангиас оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг орон нутагт эрэн сурвалжлах зорилгоор алба хаагчдад тогтмол зарлан мэдээлж ЦГ-ын гадна талын мэдээллийн самбарт байрлуулан MOVIE MAKER программ ашиглан коридорын зурагтаар гаргаж хэсгийн байцаагч нарт тараан хүн олноор цуглардаг дэлгүүрийн мэдээллийн самбарт байрлуулж, ЦГ-ын нийт алба хаагчдыг хамруулсан **“Булган аймгийн цагдаагийн газар”** хаалттай facebook group-ээр алба хаагчдад зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулан ажиллаа. Булган аймгийн Цагдаагийн газрын даргын 2015 оны 10 сарын 20-ны өдрийн “Ажил хариуцуулах тухай” 206 тоот тушаалаар ASAP санд өдөр бүр шинээр нэмэгдсэн улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн талаарх мэдээллийг Power point программ дээр хийж зурган хэлбэрт оруулан **“Булган аймгийн Цагдаагийн газар”** facebook group-т байршуулах ажлыг камерын хяналтын төвийн жижүүр цагдаа нарт хариуцуулан эрэн сурвалжлалт

хариуцсан төлөөлөгч алба хаагчид хэрхэн танилцаж байгаад хяналт тавин Цагдаагийн газрын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажиллаж байна. 2016 оны 05 дугаар сараас **“Булган аймгийн Цагдаагийн газар”** хаалттай facebook group-ийг байгууллагын дотоод ажил, алба хаагчтай холбоотой мэдээ, мэдээлэл байршуулан ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Булган аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, гэмт хэргийн замаар алдагдсан мал, эд зүйлийг эрэн сурвалжлах зорилгоор **“БУА эрэн сурвалжах”**, ASAP сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, эд зүйл, тээврийн хэрэгслийн мэдээллийг **“АСАП эрэн сурвалжлах”** хаалттай facebook group-ийг ашиглан алба хаагчдад мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна.

Эрэн сурвалжлалт хариуцсан ахлах төлөөлөгч нь ЦЕГ-ын мэдээллийн сүлжээ эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, эд зүйлийн мэдээллийг тогтмол оруулж бусад алба хаагчдаас оруулсан мэдээллийг тухай бүр хянаж, бүртгэж ажилласан байна

Тайлангийн хугацаанд төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсээс “ASAP” сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжилсан нийт 25 эрэн сурвалжлах зарлан мэдээллийг зурган хэлбэрээр facebook group-т оруулан алба хаагчдад танилцуулан ажилласан бөгөөд алба хаагч нар тухайн зарлан мэдээлэлтэй 81 хувьтай танилцаж, танилцсан талаараа “Comment” үлдээж хэвшсэн байна. “Facebook group”-т байрлуулсан мэдээллийн тоо бага байгаа нь Булган аймгийн Булган, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр, Бугат сумдад мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэмд цагдаагийн газраас алба хаагчид 2 сарын хугацаанд ажилласан, камерын хяналтын төвд үүрэг гүйцэтгэх оператор цагдаагийн орон тоо дутуугаас өдрийн цагаар 1 алба хаагч үүрэг гүйцэтгэж байсан, зарим тохиолдолд жижүүрийн офицер камерын хяналтын төвд хяналт тавин ажилласан зэрэг нөхцөл байдлууд нөлөөлсөн байна. Цаашид эрэн сурвалжлах чиглэлийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй facebook group-т байрлуулахад анхаарч ажиллах болно.

Хоёр: ХБ, МБ, прокурор, шүүхээс оргосон этгээд, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг эрэн сурвалжилж ажилласан талаар

2018 оны I улирлын байдлаар Булган аймгийн Цагдаагийн газраас ASAP сангаар гэмт хэрэгт сэрдэгдсэн болон ХБ, МБ, прокурор, шүүхээс оргон зайлсан 9 этгээдийг эрэн сурвалжлан ажилласнаас 6 этгээдийг, урьд оны үлдэгдэл эрэн сурвалжлагдаж байсан 1 этгээдийг дайчлан ажилласан байна. Үүнд:



1.2017 оны 12 дугаар сарын 03-наас 06-ний хооронд Булган аймгийн Булган сумын 2 дугаар багийн 6б хэсгийн 11-11 тоотод оршин суух иргэн Б.Пүрэвсүрэнгийн орон гэрээс

1	САБХүн	1	-	1	-	-	-	1
---	--------	---	---	---	---	---	---	---

2018 оны I улирлын байдлаар оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн ASAP сангаар улсын хэмжээнд Батхүү овогтой Мөнхбаяр - эр, 24 настай Зөрчлийн холбогдогч Б.Мөнхбаяр нь Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон зөрчилд шалгагдаж байх хугацаандаа оршин суугаа газраасаа алга болсон тул эрэн сурвалжилах ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Гурав: Хэн болох нь тогтоогдоогүй цогцос эрэн сурвалжлан ажилласан талаар

2018 оны 1 улирлын байдлаар тус аймгийн хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан хэн болох нь тогтоогдоогүй цогцос байхгүй болно. ASAP сангаар бусад аймгаас зарлагдсан цогцосыг талаар эрэн сурвалжилах ажиллагаа явуулж тухай бүр хариуг хүргүүлэн ажилласан.

Дөрөв: Галт зэвсэг эрэн сурвалжлан ажилласан талаар



2018 оны 1 улирлын байдлаар тус аймгийн хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл байхгүй болно. ASAP сангаар бусад аймгаас зарлагдсан тээврийн галт зэвсэгийг эрэн сурвалжилах ажиллагаа явуулж тухай бүр хариуг хүргүүлэн ажилласан.

Тав: Түүх соёлын дурсгалт зүйл эрэн сурвалжлан ажилласан талаар



2018 оны 01 дүгээр сарын 18-наас 19-нд шилжих шөнө Булган аймгийн Тэшиг сумын Жаргалант 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Зүйдийн шүтээн” хийдийн цоожийг хөшиж онгойлгон дэлгэмэл Бурхан 1 ш, Очирваань Бурхан /гуулин/ 1 ш, гипсээр хийгдсэн суугаа байрлалтай Бурхан 2 ш, гипсээр хийгдсэн жижиг оврын 6 ш Бурхан , 2 ш судар алдагдсан гэх хэргийг Хөх овогт Батболдын Буджав РД:/ГЙ94040612/ Гөрөөчин овогт Одонсудын Баянмөнх РД:/ГЙ00281512/ нар нь үйлдсэнийг илрүүлэн хулгайлагдсан түүх соёлын эд зүйлсийг буцаан өгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгалтын ажиллагааг явуулан ажилласан.

Зургаа: Алдагдсан тээврийн хэрэгсэл эрэн сурвалжлан ажилласан талаар

2018 оны 1 улирлын байдлаар тус аймгийн хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан тээврийн хэрэгсэл байхгүй болно. ASAP сангаар бусад аймгаас зарлагдсан тээврийн хэрэгслийн талаар эрэн сурвалжилах ажиллагаа явуулж тухай бүр хариуг хүргүүлэн ажилласан.

Долоо: Мал, амьтан эрэн сурвалжлан ажилласан талаар

2018 оны 1 улирлын байдлаар тус аймгийн хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан мал, амьтан байхгүй болно.

Найм: Эд зүйл эрэн сурвалжлан ажилласан талаар

№	Төрөл	“ASAP” санд нийт зарласан	Үүнээс		2018 онд	Үүнээс		Одоо ЭС-ж байгаа
			Олдсон	Олдоогүй		Олдсон	олдоогүй	
1	Эд зүйл	1	-	1	1	-	1	1



2018 оны 1 дүгээр улирлын тайлангийн хугацаанд Булган аймаг сайхан сум 5-р Баруун хороо гэх газарт иргэн Д.Дөлгөөнтамирын гэрт хулгай орж 42 инчийн/ Grundig/ маркын зурагт эрэн сурвалжлалт зарлан ажиллаж байна. Одоогоор тогтоогдсон зүйлгүй эд зүйлийг үргэлжүүлэн эрэн сурвалжлан ажиллаж байна.

Ес: Эрэн сурвалжлах чиглэлээр нээсэн Мөрдөн сурвалжлах хэргийн талаар

МСХэрэг	Урд байсан үлдэгдэл	Шинээр нээсэн	Хааж шийдвэрлэсэн	Одоо ажиллагаанд байгаа МСХ
2017 оны I улирлын байдлаар	3	1	0	4

Эрүүгийн цагдаагийн тасгийн хэмжээнд 13 мөрдөн сурвалжлах хэрэг ажиллагаанд байгаа бөгөөд үүнээс эрэн сурвалжлах чиглэлээр нээсэн 4 хэрэг ажиллагаанд байна. Үүнд:

1.2007 оны 07 сард Булган аймгийн Баян-агт сумын иргэн Дашцэрэн нь Тоз-8 маркийн буугаар Дашдэлэг гэгчийн толгойн тус газар нь буудаж амь насыг нь хохироосон бөгөөд дээрх галт зэвсгийг олж тогтоох чиглэлээр нээсэн “ТОЗ-8” тусгайлсан нэртэй 3200.28110003 дугаартай МСХэрэг

2.2006 оны 3, 4 дүгээр сард Булган аймгийн Баян-агт сумын иргэн Дашдэлэг, Батсайхан, Бат-эрдэнэ нар нь Тоз-8 маркийн 3 ширхэг галт зэвсэг авч яваад хээр гээгдүүлсэн бөгөөд түүнийг олж тогтоох чиглэлээр нээсэн “ЗЭВСЭГ” тусгайлсан нэртэй 3200.28110004 дугаартай МСХэрэг /ASAP санд ЭС зарлалтын №: 540003311000004, №540003311000005, №540003311000006 дугаараар/

3.2004 оны 02-р сард Булган аймгийн Гурванбулаг сумын иргэн Л.Цолмон нь Хишиг-Өндөр суман дах өөрийн төрсөн дүүгийнхээс гараад сураггүй алга болсон “ЭРЭЛ” тусгайлсан нэртэй 3200.28080003 дугаартай МСХэрэг /ASAP санд ЭС зарлалтын №: 540003311000062 дугаараар/

4.2016 оны 12 сарын 09-өөс 10-нд шилжих шөнө Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р багийн нутагт өвөлжиж байгаа Түмэн-Өлзийгийн гэрээс Г.Батбилэг нь гарч яваад сураггүй алга болсон “СУРАГ” тусгайлсан нэртэй 3200.28170001 дугаартай МСХэрэг /ASAP санд ЭС зарлалтын №: 540003316000104 дугаараар/

2017 оны I улиралд эрэн сурвалжлах чиглэлээр ГА-ын шугамаар 2 мэдээ, мэдээлэл илтгэх хуудас авч баримтжуулан шалгаж ажилласан байна.

Тус Цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас эрэн сурвалжлах чиглэлээр нийт 5 даалгавар, тогтоолыг авч даалгаварт заагдсан ажиллагаануудыг хийн даалгаврын хүрээнд эрэн сурвалжилж байсан 1 этгээдийг тогтоон хуулийн хугацаанд хариуг өгч ажилласан. Одоо сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах чиглэлээр 1 даалгаврын хүрээнд ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

2018 онд тус Цагдаагийн газраас зохион байгуулж явуулах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд эдийн засгийн албанаас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор 2018 оны 06-р сард “Мод”, 8-9-р сард “Тарвага”, 10-11-р сард “Хяналт-шийдвэрлэлт” Авлигын эсрэг болон эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2018 оны 2-р улиралд “Газар”, 1-р улиралд “Мэдээлэл” хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар Цагдаагийн газрын төлөвлөгөөнд тусгуулсан.

Эрүүгийн Цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2018 оны 03-р сарын 09-ны өдрийн МН-10/561 алба бичгээр ирүүлсэн улсын хэмжээнд явагдах буй “Сан тулгалт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө гарган батлуулж арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулах алба хаагчдын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Аймгийн прокурорын газартай хамтран “Хамтдаа шийдвэрлэе” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 03-р сарын 04-ний өдрөөс эхлэн 4 хоногийн хугацаатай зохион байгуулан ажиллаж байна.

ЭЦА-аас улсын хэмжээнд зохион байгууллагдаж байгаа “Хяналт-Сүлжээ” нэгдсэн арга хэмжээний удирдамжийг хүлээн авч аймгийн нутаг дэвсгэрт зохион явуулах салбар төлөвлөгөө гарган цагдаагийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд ЭЦА-наас ирүүлсэн сүүлийн 3 жилд хорих ангиас суллагдсан 80 этгээдийн судалгааг авч хаяг байршилыг тогтоох, хяналтанд авах нэгдсэн тулгалт хийх зэрэг ажиллагаануудыг хийж удирдамжийн дагуу 7 хоногийн 1 дэхь, 3 дахь, 5 дахь өдрүүдэд ажлын явцын мэдээг хүргүүлэн ажиллаж байна.

2018 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2018 оны 02-р сарын аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хар тамхи, хогийн олс буюу каннабис ургамалын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгт Монгол улсын хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хар

тамхитай тэмцэх газруудаас авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг танилцуулан аймгийн хэмжээнд ургаж байгаа хогийн олс буюу каннабис ургамалын устгалд байгаль хамгаалах сангаас 50.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан.


-Хэрэг бүртгэх албаны чиглэлээр

2018 оны 01 дүгээр сард Хэрэг бүртгэх тасаг нь харьяалан шалгаж шийдвэрлэх зөрчлийн шинжтэй 42 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 13 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 4 зөрчлийг хялбаршуулсан журмаар торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн, 16 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 3 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу бусад тасагт шилжүүлж шийдвэрлэсэн.


Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/11, 2018 оны А/35 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 2/48 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Үүрэг, ажлын чиглэл”, Хэрэг бүртгэх албаны Дэд бөгөөд дүн шинжилгээ, үнэлгээ хяналт шалгалтын хэлтсийн даргын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 12 а/104 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Үүрэг, ажлын чиглэл”-үүдийг тус тус хүлээн авч хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллалаа. Ажлын хэсгийг тус Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан байгуулж 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 04-ны өдрийг дуустал хугацаанд Хэрэг бүртгэх тасагт харьяалагдан шалгаж байсан зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл, зөрчлийн хэргийг Нийтийн хэв журам хамгаалах тасагт шилжүүлэх, Мөрдөн байцаах тасаг, Эрүүгийн цагдаагийн тасгуудад шалгаж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргүүдийг Хэрэг бүртгэх тасагт шилжүүлэн авах ажлыг хийж гүйцэтгэсэн.


Хэрэг бүртгэх тасаг нь 2018 оны 01 дүгээр улиралд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 13 гомдол, мэдээлэл хүлээн авч нийт хүлээн авсан гомдол мэдээллийг хуулийн анхны хугацаанд шалгаж 13 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж 100 хувь шийдвэрлэж ажилласан.



2018 оны 01 дүгээр улиралын байдлаар хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22 бүртгэгдсэн нь 2017 оны мөн үеээс 6 хэргээр буюу 21.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үлдэгдэл 4 хэрэг нийт 26 хэрэг шалгаснаас хэрэг бүртгэлтийн 2 хэргийг хааж, харьяаллын дагуу 1 хэрэг шилжүүлж, харьяаллын дагуу 1 хэрэг хүлээн авч, 16 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, хэрэг бүртгэлтийн 8 хэргийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд түдгэлзүүлсэн болон түдгэлзүүлсэнээс сэргээсэн хэрэг бүртгэлтийн хэрэг байхгүй.



2018 оны 01 дүгээр улиралын байдлаар мөрдөн байцаалтын нийт 26 холбогдогчтой 17 эрүүгийн хэрэг шалгаснаас 11 хэрэгт хялбаршуулсан журмаар шалгаж шүүхэд шилжүүлэх мөрдөгчийн саналтай шилжүүлж хэргийг шийдвэрлэн ажилласан. Шүүхэд шилжүүлэн шийдвэрлэсэн эрүүгийн хэргээс гологдолоор нэмэлт ажиллагаа хийхээр шүүх, прокуророос буцсан хэрэг байхгүй.



Тайлангийн хугацаанд шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаасан 2017 оны дугаартай 2 хэргийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч

мөрдөн шалгах ажиллагааны 1 дүгээр хугацаа сунгуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулан шалгаж байна.

Тус Хэрэг бүртгэх тасагт эзэн холбогдогч нь тогтоогтоогүй, оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн мөрдөн байцаалтын хэрэг байхгүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 1 яллагдагчтай, хилийн хориг тавигдсан яллагдагч байхгүй болно.

-Мөрдөн байцаах албаны чиглэлээр

Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 33 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 26, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 7. Өмнөх оны үлдэгдэл 12 хэрэг бүртгэлтийн хэрэг дээр шинээр 26 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж нийт 38 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас эрүүгийн хэрэг үүсгэн шууд яллагдагчаар татсан 6, хэрэгсэхгүй болгох саналтай 16. Одоо 16 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өргөдөл гомдол, мэдээллийн үлдэгдэлгүй 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт 39 хэргээс 25 холбогдогчтой 23 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, харьяалалын дагуу 5 холбогдогчтой 5 хэргийг өөр бусад газарт шилжүүлж одоо 12 холбогдогчтой 11 хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүхээс 2 холбогдогчтой 2 хэрэг, прокуророос нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан 9 холбогдогчтой 8 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна

Гэмт хэргийн улмаас иргэн аж ахуйн нэгж байгууллагад 68,725,000 төгрөгийн хохирол учирснаас 39,530,000 төгрөгийн хохиролыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж ЭХХШТХ-н 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хохиролыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах, болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор 43.800.000 төгрөгний эд хөрөнгийг битүүмжлэн ажилласан. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 57,5 хувьтай байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор мөрдөн байцаагчийн мэдэгдэл 145-г бичиж хариу авсан. Хариу авалт 100 хувьтай байна. Мэдэгдэлийн мөрөөр шалгах ажиллагааг 8 удаа зохион байгуулсан.

ЭХХШТХ-н 6.3 дугаар зүйлд заасны дагуу хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгч нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 18 хэрэгт бичгээр зааварчилга өгч биелэлтийг нь хангуулан ажилласан.

ЦБҮАЖ код 306-д заасны дагуу мэргэжлийн зөвлөлөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа ээдрээ төвөгтэй, олон үйлдэл холбогдогчтой, олон хүн хохирсон, шийдвэрлэхэд бэрхшээл учирч байгаа хэргүүдийг уншиж мэргэжлийн болон мөрдөн байцаалтын арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 3 хэрэгт зааварчилга өгч, шинээр хэрэгжиж буй Эрүүгийн хууль, ЭХХШТХ-г хэрэгжүүлэхэд гарч буй зөрчил дутагдлыг арилгах зорилгоор нийт мөрдөгч нарт 1 удаа зааварчилга өгсөн.

Аймгийн прокурорын газарт шинэ хууль хэрэгжиж байгаатай холбогдуулан гарч байгаа хүндрэл бэрхшээл цаашид авч хэрэгжүүлэх арга замын талаарх уулзалтыг 2018 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр удирдах албан тушаалтны хүрээнд зохион байгуулсан. Уулзалтанд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа З.Гомбо, аймгийн ерөнхий прокурор Ж.Лхагвасүрэн, орлогч прокурор Болорпүрэв, Дэд бөгөөд ЭЦТ-н дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Гантөмөр, МБТ-н дарга, цагдаагийн хошууч Л.Шинэбаяр нар



оролцсон.

2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр МБТ, ЭЦТ"-с Аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг байгуулж өнгөрсөн онд гаргасан алдаа дутагдал 2018 онд сар бүрийн 5-ны өдөр хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж шинэ Эрүүгийн хууль, ЭХХШТХА-ны явцад гарч буй зөрчил дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж байхаар шийдвэрлэсэн. Мөн тухайн сард шийдвэрлэх хэргийн график гаргаж өмнөх сарын хэрэг шийдвэрлэх графикайн биелэлтийг тооцон ажиллаж хэвшсэн. Тайлангийн хугацаанд нийт 4 удаа хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан.

2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Мөрдөн байцаах тасагт шалгагдаж байсан Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дүгээр зүйлийн 2.5 дахь хэсэгт зааснаас бусад энэ бүлэгт заасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт 4 хэргийг Хэрэг бүртгэх тасагт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

-Замын цагдаагийн албаны чиглэлээр

2017 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, осол 6 бүртгэгдсэн байна.

2018 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 40 % буурсан үзүүлэлттэй байна.

Хоёр: Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил:

2018 оны 01-р улиралд нийт 2116 зөрчил илрүүлсэн. Үүнээс эрхийн үнэмлэхтэй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 59, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 2, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 16, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 59 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар эрхийг хасаж 23.600.0 сая төгрөгөөр, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 16 хүнийг 3.200.0 төгрөг, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 2 хүнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30

хоногийн хугацаагаар баривчлуулан, 1934 хүнийг 71.002.000 мянган төгрөгөөр торгож, 77 тээврийн хэрэгслийг түр саатуулан ажиллалаа.

Хөвсгөл аймагт “Хөх сувд” мөсний баяр 02 дугаар сарын 23-25-ны хооронд зохион явагдахад их хэмжээний тээврийн хэрэгсэлийн урсгал явж байгаатай холбогдуулан Түлүүгийн даваанаас Уньт хүртэл 150 замд хөдөлгөөнт эргүүлээр 2 алба хаагч, Гуртын гүүрэн дээр 24 цагийн хяналтын постыг ажилуулан орон нутгаас бүртгэлийн 1 ажилтан, хилийн цэргийн 086 дугаар бүхий заставаас 2 ахлагчийг томилуулан хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Тус тасгаас тухайн өдөр томилгоотой байгаа алба хаагчдыг өглөө бүр 08 цаг 30 минут, орой 18 цаг 00 минутанд жагсааж, ерөнхий жижүүр болон ёс журмын хариуцлагатай эргүүлүүдээр үүрэг зааварчилга өгч үүрэг гүйцэтгүүлж байгаа ба хорио цээрийн дэглэмийн дагуу аймгийн хэмжээнд нийт 42 хяналтын цэг байгаагаас замын цагдаагийн алба хаагчид 11-н цэг аймгийн төвийн 3 постонд 7-10 хоногоор 7 алба хаагч, Рашаанд суманд 36-45 хоногоор 4 алба хаагч, Гурван булаг суманд 25 хоногоор 1, Хутаг-Өндөр суманд 14 хоногоор 1, Сайхан суманд 21 хоногоор 1 алба хаагч буюу ахлах зохицуулагч 1, зохицуулагч-3, цагдаа зохицуулагч 10 хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Баяннуур суманд хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай ээлжлэн 24 цагаар байнгын постонд 1 зохицуулагч үүрэг гүйцэтгэж байна.

Тус тасгаас 3 дугаар улиралд урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

“Булган АЗЗА” ТӨХК-д, “Шороо орд маининг” ХХК, “Цагдуултайн ундрага” ХХК, “Эрдмийн өргөө цогцолбор сургууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба”, “Булган хот тохижуулах анги”, “ЭБЦТС” ТӨХК, “Булган мээж”, “Их газар” ХХК-д гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замыг засуулах, тэмдэг, тэмдэглэлгээг сэргээх, нөхөн тавиулах чиглэлээр 13 мэдэгдэл, албан шаардлага өгч, мэдэгдлийн хариуг авч ажиллалаа.



Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2-р 12 жилийн сургуулийн 45 багш ажилчдын дунд Замын хөдөлгөөний дүрмийн сургалт, 10 хүртэлх насны хүүхдүүдийн эцэг эх, анги хариуцсан багш нартай уулзаж, 10 хүртэлхи насны хүүхдүүдийг Замын хөдөлгөөнд харгалзах хүнгүйгээр оролцуулахгүй байх талаар баталгаа авч, сургалт зохион байгуулж ажилласан.

Аймгийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр элэгдэж муудсан самбаруудыг сольж 1 ширхэг шинэ зурагт самбарыг АГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр хийж, байрлуулан ажиллалаа.

Өвлийн улирал эхэлж цас орсноос шалтгаалан автозамын зорчих хэсэгт халтиргаа



гулгаа үүсэх, цасан болон шороон шуурганаас шалтгаалан зам орчны үзэгдэх орчин хязгаарлагдмал болох, байгалийн таагүй үзэгдлийн үед осол, хэргээс урьдчилан сэргийлж замын хөдөлгөөнд оролцогч жолооч, зорчигчдод санамж сэрэмжлүүлэг тараан, өвлийн улирлын дугуй тавьж хэрэглэхийг хөдөлгөөнт эргүүлд хяналт шалгалтын явцад алба хаагч нарт хууль эрх зүйн зөвлөгөө өгч, Булган аймаг дахь TV-9 салбар, FM-106.5, мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Орхон, Хялганат тосгоны “Хараацай” Цэцэрлэг, Хутаг-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд сургалтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллалаа.



Осол гэмтлээс хамтдаа сэргийлье сарын аяны хүрээнд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгт эцэг, эх, анги удирдсан багш нарт сургалтыг 3 удаа орсон.

Улсын чанартай замын тэмдэг тэмдэглэлийг сайжруулах зорилгоор 01 дүгээр сарын байдлаар Рашаант, Баян-нуур, Дашинчилэн сумын төвийн замын тэмдэг, тэмдэглэгээг шинээр хийлгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллаж байна



“Сар шинэ нэгдсэн” арга хэмжээний хүрээнд 7 заалт бүхий төлөвлөгөө гарган ЗЦТ-ийн дарга, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэ-Очир батлуулан гудамж замд хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж ирэнсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засуулж хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн гудамж замд хяналт шалгалтанд гарч ажиллах хугацаанд хууль бус нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг жолооч нарыг илрүүлэн тэднээс дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан авч ажиллаж байна.

Тус тасгаас Булган аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа болон аймгийн төв дотор хөдөлгөөнд оролцож байгаа нийт жолооч нарын тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, жолооч нарын гэрэл хэрэглэх соёлыг дээшлүүлэх зорилгоор жолооч нарт сургалтыг зохион байгуулж ажиллаа. Уг арга Улсын чанартай замын тэмдэг тэмдэглэлийг сайжруулах зорилгоор аймгийн засаг даргын А/54 тоот захирамжаар 2 дугаар сард замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалтыг Тэшиг, Хутаг-өндөр суманд ажлын хэсэг байгууллагдаж ажиллалаа.

Булган цагдаагийн газар раге хуудас 12 удаа, Орон нутгийн замын цагдаа раге хаягт 13 удаа, Баян-нуур сумын тамгын газар раге хаяг 2 удаа, Булган замын цагдаагийн тасаг facebook group-д 15 удаа сэрэмжлүүлэг болон хийж хэрэгжүүлж буй үйл ажиллааг иргэдэд хүргэж ажиллаж байна.

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.02.14-ний өдөр Хот тохижилт



үйлчилгээний ангийн инженер Дөлгөөнтэй хамтарч үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 478 гэрэлтүүлэг байсныг Хот тохижилт үйлчилгээний ангиар засварлуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Орхон-Булган, Булган-Хөвсгөл аймгуудыг холбосон авто замуудад цас ихээр орсонтой холбогдуулж үзлэг шалгалтыг Булган “АЗЗА” ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй хамтран хийж шуурсан цэгүүдийн цасыг цэвэрлүүлж ажилласан.

Авто замын халтиргаа гулгаа, хаагдсан замын талаар тухай бүр нь Булган замын цагдаагийн тасаг, Орон нутгийн замын цагдаа хаяганд байршуулсан.

Булган сумын 5-р багийн нутаг Спортын ордноос эмнэлэгийн зүүн талын замтай холбох, Булган сумын 5-р багийн Мэргэжил сургалтын төвийн араас гэр хорооллын хөндлөн замтай холбож асфальтан зам тавих ажлуудыг Булган-АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэ, Булган сумын засаг даргын орлогч Оюунбат нартай уулзсан.

Булган аймгийн Булган суманд 3-н гэрлэн дохио байрладаг ба Булган сумын 5 дугаар багт баруун 4 замын уулзвар, холбооны 3 замын уулзвар, зүүн 4 замын уулзваруудад гэрлэн дохио ажиллаж байна.

Булган аймгийн төвд 54 цэгт 86 ширхэг камер байрлуулсанаас 10 камер засварлагдан одоо 44 камер ажиллаж 42 камер ажиллахгүй байна. Үүнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих 10 камераас 6 камер ажиллаж 4 камер ажиллахгүй болсон байна.

Булган-АЗЗА ТӨХК-ны хариуцсан Булган сумын төвөөр дайран өнгөрч буй авто замуудын тэмдэгт үзлэгийг хийж шинээр 3 тэмдэг байрлуулах саналтай албан мэдэгдэл хүргүүлсэн.

Булган-АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй уулзаж Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хүйтний гүүрэнд хайс хашлага хийлгэх санал 1 удаа өгсөн.

Булган аймгийн хэмжээнд ашиглагдаж буй 3 улсын чанартай авто замуудын хашлагын дагуух гэрэл цацруулагч муудаж бүдгэрсэн, мөн цацруулагч байхгүй газруудад цацруулагчтай болгож засварлах талаар Булган-АЗЗА ТӨХК-нд албан мэдэгдэл хүргүүлсэн.

Булган-АЗЗА ТӨХК-иар Бугат сумын Зоон даваа, Хутаг-Өндөр сумын Төлүүгийн давааны авто замын зорчих хэсгийн мөстсөн хэсгийг хусуулж цэвэрлүүлсэн.

Булган сумын 5-р багийн нутаг Спортын ордноос эмнэлэгийн зүүн талын замтай холбох, Булган сумын 5-р багийн Мэргэжил сургалтын төвийн араас гэр хорооллын хөндлөн замтай холбож асфальтан зам тавих ажлуудыг санал хүргүүлсэн.

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.03.19-ний өдөр үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 582 гэрэлтүүлэг хэвийн асч байна.

Эрдэнэт-Булган, Булган-Хөвсгөл холбосон авто замуудад цас орсонтой холбогдуулж үзлэг шалгалтыг Булган-АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй хамтарч цас ихээр шуурсан цэгүүдийг 1 удаа хусуулж ажилласан.

Булган-АЗЗА ТӨХК-д Замын эвдэрч тахийсан тэмдгийг засварлах талаар хүргүүлсэн. Цагдуултайн ундарга, шороон орд манинг ХХК -д “могойн гол”-ын уурхайгаас нүүрс тээвэрлэхдээ даац хэтрүүлж байгаа зөрчилд жолооч нарт хариуцлага тооцож дахин зөрчил гаргахгүй байх талаар албан мэдэгдэл өгсөн.

Авто замд халтиргаа гулгаа үүссэн болон нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний явц үр дүнгийн талаар Булган замын цагдаагийн тасаг, Орон нутгийн замын цагдаа хаяганд тус бүр 1 удаа байршуулсан.

Ачааны автомашин, ачаа тээвэрлэлт, Тусгай дууд гэрлэн дохио, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж, Тээврийн хэрэгслийн улсын дугаар гэсэн арга хэмжээг зохион байгуулсан.

-Нийтийн хэв журам хамгаалах ажлын чиглэлээр

Булган аймаг дахь цагдаагийн газраас Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339, 340 дүгээр тогтоолын дагуу Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах талаар хийх дадлага сургуулилтанд 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 16.00 цагаас 17.00 цагийн хооронд бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын орлогч даргаас 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/303 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Дадлага сургууль зохион байгуулах тухай”

албан бичгийг хүлээн авч алба хаагч нарт танилцуулан, алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэлийг хангуулан ажиллалаа.

Алба хаагчдын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр ажиллах ажлын төлөвлөгөөг танилцуулан үүрэг, ажиллах чиглэлийг тодотгон өгч үүрэгжүүллээ. Мөн гамшгийн үед алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэлийг хангуулах зорилгоор алба хаагчдын аранзны байдалд үзлэг шалгалтыг явуулж дүнг нэгтгэн Цагдаагийн газрын дарга болон аймгийн онцгой байдлын газрын хяналт тавьж буй алба хаагчид дүнг нэгтгэн өгсөн.

Гамшгийн үеийн эрсдлийг бууруулах дадлага сургууль улсын хэмжээнд 2018 оны 03 дугаар 29-ны өдрийн 16.00 цагт “Зарлан мэдээлэх” дохионы зарлан мэдээллээр алба хаагчдыг газрын байрнаас гарган байрны баруун талд байрлах жагсаалын талбайд жагсаан ранзанд үзлэг шалгалт хийж дүн мэдээг аймгийн онцгой байдлын газарт танилцуулгаар хүргүүлэн ажиллаа.

Гамшгийн үеийн зарлан мэдээллийн хоёр дахь дохио буюу 16.15 минутанд алба хаагчдыг газар хөдлөлтийн бүсээс /Цагдаагийн газрын байрнаас/ 5-7 минутанд гаргаж аюулгүй газарт хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа



Танхимын болон дадлага сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр аймгийн ОБГ-ын ажилтан ахлах дэслэгч Б.Ганбаярыг урьж алба хаагчдын дунд Гамшиг ослын үед хэрхэн ажиллах талаар сургалт хийлгэсэн.



Зарлан мэдээллийн 1 дэхь дохио буюу 16.00 минутанд алба хаагчдыг аюулгүй бүсэд хүргэсний дараа нэрсээр тулган бүртгэхэд ирвэл зохих 85 алба хаагчаас хөдөө албан ажлаар явсан 27, өвчтэй 3 алба хаагч, ээлжийн амралттай 3, бусад 52 алба хаагч, хөдөлгөөнт эргүүлийн 2 автомашин, гар станц-4, суурин станц-1-тэйгээр бүрэн цугларч дадлага сургуулалтыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд Рашаант, Гурванбулаг, Бугат, Булган, Сайхан, Хишиг-өндөр суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоож, нийт 45 постонд цагдаагийн газраас 27 албан хаагч, 7 автомашин, үүрэг гүйцэтгэж байна. Постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарыг 7-14 хоногийн хугацаатай постонд үүрэг гүйцэтгэх томилгоог хийж алба хаагч бүрт баталгаа зааварчилгааг өгч цагдаагийн газрын

даргаар батлуулан ажиллаж байна. Булган суманд хорио цээрийн дэглэм тогтоосонд хяналт тавих 11 хяналтын цэгт /пост/ цагдаагийн 2 офицер, 9 ахлагч, нийт 11 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. Хорио цээрийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт Цагдаагийн газрын даргаас 2018 оны 02 дугаар 28-ны өдрийн 38/01-322 албан бичгээр 8 заалт бүхий ажлын үүргийг хүргүүлэн, алба хаагч бүрээр сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх талаар **баталгаа** гаргуулан гарын үсэг зуруулж баталгаажуулж ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа З.Дашдаваагийн 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 4/1175 албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийг цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан, хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт хүргүүлэн ажилласан.

Хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа З.Гомбо, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэ-Очир, Олон нийттэй харилцах ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Ариунчимэг, сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батмөнх, эмч, цагдаагийн дэслэгч Б.Баярчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр хяналтын цэгүүдээр тойрон, үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарын биеийн эрүүл мэндийн байдалд үзлэг хийж, сэтгэл зүйчээс ярилцлага хийн, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргүүлэн, Зөрчлийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Аймаг, сумын Засаг даргын захирамж, Цагдаагийн Ерөнхий Газрын дэд даргаас өгсөн ажлын чиглэл, Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг даалган эдгээр материалыг гарын авлага болгон өгч, сахилга ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан халуун аарц, хоолоор үйлчлэн дэмжлэг үзүүлэн ажилласан.

2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/103 тоот захирамжаар байгуулагдсан мал, амьтаны гоц халдварт “Шүлхий” өвчинөөр өвчилсөн байж болзошгүй малыг олж тогтоох “Тандалт”-ын багт цагдаагийн газраас ахлах байцаагч хэсгийн байцаагч нараас 5-ыг томилон аймгийн онцгой комиссын гишүүд, мэргэжилийн байгууллагын ажилтан нартай хамтран үзлэг, тандалт, вакцинжуулалт, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна

а. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

2018 онд зохион байгуулах нэгдсэн болон тусгай арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу болон ЦЕГ-ын харъяа нэгжүүдээс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу 1-р улиралд “Шинэ жил”, “Сар шинэ”, “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Согтуу”, “Хяналт”, “Хамтдаа шийдвэрлэе”, “Сэрэмжилье нэгдье”, “Хуулиа мөрдье”, “Хуулийн хэрэгжилт”, “Илрүүлэлт, Эрэн сурвалжлалт, Шийдвэрлэлт” зэрэг улсын хэмжээнд 6, аймгийн хэмжээнд 3, хэсэгчилсэн 4 арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3664 иргэнийг хамруулан сургалт, мэдээлэл 37, уулзалт хэлэлцүүлэг 2, өдөрлөг 2, уралдаан, тэмцээн 2 удаа тус тус зохион байгуулан ажиллалаа.

Булган аймгийн хэмжээнд “Сар шинэ-Аюулгүй тээвэр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 2569 тээврийн хэрэгсэл шалгаснаас 612 зөрчил илрүүлж 612 жолоочийг 14.105.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ сэргээхээр ирсэн 14 жолооч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Булган жолоо”, “Залман Хангай” зэрэг аж ахуйн нэгжүүдийн 20 жолооч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн

төвийн 54 багш, ажилчдад “Миний жолоо” автокурсийн захирал Ш.Дуламсүрэнтэй хамтран Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн оноо тооцох журам, Замын хөдөлгөөний дүрмээр сургалтуудыг зохион байгуулж ажиллаа.

Арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ-тай хамтран аймгийн хэмжээнд нийт архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг 196 цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж, 150ш санамж, зөвлөмжийг тарааж ажиллалаа. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 214 цэг байдгаас архи, согтууруулах ундаа худалдаалах 178, түүгээр үйлчлэх 36 цэг байна. Шалгалтаар үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй М-Ти-Эс ХХК-д үйлдвэрлэгдсэн 0,5л-ээр савлагдсан 2 ширхэг “Монгол Стандарт” архи, Герман улсад үйлдэрлэгдсэн 1 литрын импортын Sangria дарсыг хураан авч, шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний дүнгээр стандартын шаардлагыг хангасан байв.



Аймгийн Стандартчлал хэмжил зүйн газар, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Иргэний зөвлөл хамтран Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 цахим тоглоомын газруудад хяналт шалгалт явуулж, холбогдох хууль эрх зүйн акт, стандарт шаардлагын хэрэгжилт, хүүхдэд үзүүлж буй үйлчилгээ хэрхэн байгаа талаар шалгаж, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.



“Аюулгүй тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан сумдын ЗДТГ, Авто тээврийн газар, бусад аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хяналтын пост, зам дагуу хяналт шалгалтаар ажиллаж нийт 585 машин шалгаж зөрчилтэй 109 жолоочийг 3,034,000 төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 14 зөрчил илрүүлэн, 11 жолоочийн эрхийг хасч, 3 хүнийг 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар санамж, сэрэмжлүүлэг тараалаа.



Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан тавих нэгдсэн арга хэмжээг Соёлын ордонд зохион байгуулан, иргэдэд хийсэн ажлаа танилцуулан, иргэдийн санал хүсэлтийг амаар болон саналын хуудсаар хүлээн авч ажилласан бөгөөд арга хэмжээний үеэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гарган ажилласан Булган сумын 4-р багийн иргэн Д.Мөнхөрмаа, 3-р багийн иргэн Д.Хишигдэлгэр, мөн Н.Баасанжаргал даргатай Тохижилт үйлчилгээний ангийг Цагдаагийн газрын баярын бичиг, үнэ бүхий зүйлээр тус тус урамшуулж, урлагийн хэсэгчилсэн тоглолтыг иргэдэд толилууллаа. Тайлан тавих нэгдсэн арга хэмжээний үеэр “Шар нохой жилийн хийморь” азтанаар 3 иргэнийг шалгаруулан Батламж, дурсгалын зүйлээр урамшуулж, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилсан шторк, цагдаагийн газрын үйл ажиллагааны видео тайлан зэргийг дэлгэцээр үзүүлэх, үйл ажиллагааны сурталчилгааны самбар, Цагдаагийн байгууллагад хэрэглэгдэж буй техник хэрэгсэл зэргийг байрлуулан сурталчлан ажилласан.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн ш бөгөөд хугацаа болоогүй 5 мэдэгдэл байна.

Булган суманд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 23 аж ахуйн нэгжүүдийн захирал, ажилчдад Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдэж буй арга, газар, цаг хугацаа, субъект, хор уршигийн талаар мэдээлэл хийж уг төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлагын талаар сургалт явуулан баталгаа гаргуулан авсан.



Аймгийн төвд болон 5 суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38/01-309 албан тоотоор сумын нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахгүй байх талаар захирамж гаргуулах хүсэлтийг хүргүүлсэнээр тухайн сумдын Засаг даргын захирамжаар тодорхойгүй хугацаагаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг хориглосон захирамж гаргуулж, аж ахуйн нэгжийн захиралуудад захирамжыг танилцуулан худалдан борлуулж байгаа архи согтууруулах ундааг тоолж лацдан борлуулахгүй байх баталгаа гаргуулах ажлын зохион байгуулсан. Дээрх захирамжийн хэрэгжилтэнд өдөр тутам хяналт тавьж, архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай Булган сумын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/55 дугаар захирамжийг зөрчиж, бусдад архи худалдсан Булган аймгийн Булган сумын 1-р багт байрлах “Хас” дэлгүүрийн эзнийг Зөрчлийн тухай хуулийн 15.2.1.3-т заасны дагуу 500,000 төгрөгөөр торгож хариуцлага тооцсон.

“Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” аяныг зохион байгуулан Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Улаан загалмай нийгэмлэг, 2-р цэцэрлэгтэй хамтран Булган сумын хүнд нөхцөлд амьдарч байгаа 8 өрхийн 21 хүнд дулаан хувцас өгч, урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгт хамруулан 1 эмэгтэйн нийгийн асуудлыг шийдэж ажлын байраар хангаж, 2 хүүхдийг цэцэрлэгт хамруулж ажиллалаа.



Мөн “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 8-9 дүгээр ангийн 158 охид, 68 хөвгүүдийг өсвөр үеийн эмчийн үзлэгт хамруулан, ерөнхий боловсролын сургуулийн орчинд багш, сурагчид гар утас, таблет хулгайд алдах, цахим орчинд донтох зэргээс урьдчилан сэргийлж аймгийн Боловсрол соёл урлагийн газарт санал хүсэлтийг хүргүүлсний үр дүнд аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/01 дугаар тушаалаар хичээл сургалтын цагаар ухаалаг гар утас, таблет хэрэглэхийг хязгаарласан тушаал гаргаж, иргэдэд сурталчлан ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Архигүй ирээдүй”, “Хулгайлах гэмт хэргээс сэрэмжилье” сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдаан, хууль эрх зүйн мэдлэгийг бататгах АХА, “Асуулт-хариулт” тэмцээн зэрэг ажилд аймаг, сумын ГХУСАЗЗ-өөс 420,000 төгрөгийн санхүүжилтээр тус тус зохион байгуулж, цахим хуудсаар сурталчлан ажиллалаа.



Архидан согтуурахтай, гэр бүлийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 2684ш санамж, зөвлөмжийг аймаг, сумын ГХУСАЗЗ-ийн 310,000 төгрөгийн санхүүжилтээр тус тус хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэсэн.



Мөн Гэр бүлийн хүчирхийлэл, тэмцэх, зам тээврийн осол хэргээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын урьдчилан сэргийлэх, шүлхийн өвчний дэглэм зөрчихгүй байх талаар зэрэг нийт санамж, зөвлөмжийг аймаг, сумын санхүүжилтээр тус тус хэвлүүлэн үйл ашиглаж байна.



архидан согтуурахтай урьдчилан сэргийлэх, эсрэг гэмт хэргээс хорио цээрийн 15 төрлийн 1590 ш ГХУСАЗЗ-ийн ажиллагаандаа

б. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 5.1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог хангах ажлын хүрээнд 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/21 тоот захирамжаар батлагдсан журам, хуваарийн дагуу 2017 онд олон нийтийн эргүүлийг сайн зохион байгуулж, ажилтан, алба хаагчид нь санаачлагатай ажилласан дараах байгууллагуудыг аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газраас хамтран урамшууллаа. Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Биеийн тамир спортын газар, Нэгдсэн эмнэлэг Эрдмийн өргөө цогцолбор сургууль, 2-р цэцэрлэг, Хөдөлмөр халамж үйчилгээний газар, Номын сан, Мэргэжлийн хяналтын газар зэрэг 9 байгууллагад дурсгалын зүйлийг аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний үеэр

аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий, Хууль эрх зүйн хэлтсийн дарга П.Хишигдаваа, Цагдаагийн газрын дэд бөгөөд ЭЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Гантөмөр нар гардуулан өгсөн.



Аймгийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/21 тоот захирамжийн дагуу 2018 оны 1-р улиралд албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчидаас батлагдсан графикийн дагуу 7 хоног бүрийн Баасан, бямба, ням гарагууд, баяр ёслолын өдрүүд, малын гоц халдварт өвчний хороо цээрийн дэглэмийн үед давхардсан тоогоор 123 удаа 1645 хүн олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 86 зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, 177 аж ахуйн нэгж, байгууллага, 184 иргэнд зөвлөгөө өгч ажиллалаа.



Аймгийн хэмжээнд 12 суманд 12 Олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 1-р улиралд Олон нийтийн цагдаагийн ажилтнууд хариуцсан нутаг дэвсгэрийн 105 айл өрхөөр орж санал хүсэлтийг нь хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулан, эргүүл шалгалтанд ажиллан, 1340 хүүхдэд сургалт, яриа таниулга хийж, архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 15 хүнийг өөрийн хяналтанд эрүүлжүүлж, 10 хүнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 5 удаа хэргийн газрын хамгаалалт хийж, нийт 28 зөрчил илрүүлэн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаадаа хүлээлгэн өгч арга хэмжээ авхуулж ажилласан байна.

Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран "Хуулиа мөрдье-21" арга хэмжээний хүрээнд хууль сурталчлах өдөрлөг, сургалтыг зохион байгуулж 45 байгууллагын 100 залуучуудыг хамруулан "Архины хор уршиг", "Зөрчлийн тухай хууль", Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл заалтаар сургалт мэдээлэл өгч, архидан согтуурахын хор уршигийн талаар

120ш зөвлөмж тараасан бөгөөд өдөрлөгийн үеэр залуучууд "Хуулиа мөрдье-21" арга хэмжээнд нэгдэж байгаагаа илэрхийллээ.



Тус аймгийн төв болон Рашаант, Гурванбулаг, Сайхан, Бугат, Хишиг-Өндөр сумын нутаг дэвсгэрт 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 01-ийг хүртэлх хугацаанд мал, амьтаны гоц халдварт Шүлхий өвчин гарч аймаг, сумдын Засаг дарга нарын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож, нийтийг хамарсан арга хэмжээ, сургалт, соёл, урлагийн арга хэмжээнүүд болон архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосонтой холбогдон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 712 оюутан, ерөнхий боловсролын сургуулийн 5530 сурагч, насанд хүрсэн 380 иргэн, зорилтот бүлгийн /архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, гэр бүлдээ айдас түгшүүр төрүүлдэг/ 74 иргэнийг тус тус хамруулан архины хор уршиг, "Хорт зуршил" Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалт, бэлгийн амьдралын эрүүл ахуй, бэлгийн замын халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт, мэдээлэл өгч, аяны талаарх мэдээлэл сурталчилгааг хийж ажиллалаа.



Багийн Засаг дарга, багийн эмч, Иргэний зөвлөлийн гишүүдтэй хамтран Хариуцсан нутаг дэвсгэрийн 759 айл өрхөөр орж, Зөрчлийн тухай хууль, АСТТХ, Эрүүгийн хуулийн зарим заалтыг тайлбарлан өгч, АСТТХ, Зөрчлийн хуулиар болон сар шинийн баярын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг тараалаа.



Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан хүүхэд, багачуудыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх асран хамгаалагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах “Эцэг эхийн эргүүл School police” хуваарийн дагуу ажиллуулах сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн удирдлагаар хангаж ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн ойролцоох замуудад явган хүний гарц дээр 2018 оны 1-р улиралд 104 эцэг, эх, асран хамгаалагч эргүүлд ажилласан байна.

-Шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шүүх хуралдааны журам сахиулах, яллагдагч шүүгдэгчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх ажиллагааг удирдлагаар хангах, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтыг тасралтгүй тавьж, зөрчил дутагдал гаргуулалгүй ажиллалаа.

2018оны 1 дүгээр улиралын байдлаар 12 шүүгч 25 захиргааны ажилтан нийт 36 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг явуулж байна. 43 иргэний 26 захиргааны 1 эрүүгийн, иргэний 26 захиргааны 1 эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хурал 7 нийт 77 шүүх хурал, 10 удаа хамгаалалтаар, 10 шүүгдэгчийг хуяглан хүргэж, 13 оролцогчийг албадан ирүүлэх ажиллагааг тус тус шуурхай хэрэгжүүлж ажилласан.

Булган аймгийн Цагдаагийн газрын шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг нь хэсгийн ахлах байцаагч, харуулын цагдаа-4, шүүх хуралдааны хамгаалалтын цагдаа-2, нийт 7 орон тоотой батлагдсанаас өнөөдрийн байдлаар хэсгийн дарга-1, харуулын-2, хамгаалалтын-1 цагдаа тус тус ажил үүрэг гүйцэтгэж байна.

Булган аймгийн Цагдаагийн газрын Шүүх, Шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг нь ахлах байцаагч-1, харуулын цагдаа-4, шүүх хуралдааны хамгаалалтын цагдаа-2, нийт 7 орон тоотой батлагдсанаас ахлах байцаагч-1, харуулын-4, хамгаалалтын-1 цагдаа тус тус ажил үүрэг гүйцэтгэж байна. Шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн бичиг баримтыг шалган энгэрийн тэмдэг зүүлгэн, зөв соёлтой харьцаж, түргэн шуурхай үйлчилж, зохих журмын дагуу 2018 оны 1-дүгээр улиралын байдлаар нийт 185 иргэнийг нэвтрүүлэн ажиллаа. Тус шүүхийн байранд ажиллаж буй шүүхийн захиргааны ажилтан, цагдаагийн алба хаагчийн харилцаа хандлагад тогтмол хяналт тавьж, ахлах байцаагчийн зүгээс үүрэгжүүлэн гүйцэтгэл, үр дүнг 7 хоног бүр тооцон ажиллаж байна

Шүүхийн байрны камерын хяналт, өрөө тасалгаа, цонхны цоож, лацны бүрэн бүтэн байдалд өдөр тутам хяналт тавьж, бүртгэлийн дэвтэртэй танилцан үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Тус шүүхийн тамгын газрын даргад хандаж, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нэгдүгээр давхрын бүх цонхонд хамгаалалтын төмөр тор /решотка/ суурилуулах талаар санал хүсэлт, зөвлөмжийг албан

бичгээр хүргүүлж, богино хугацаанд шийдвэрлэх тухай хариуг шүүхийн тамгын газраас хариу өгсөн.

Тус шүүхийн барилга байгууламжийн өрөө тасалгаа, цонхны цоож, лацны бүрэн бүтэн байдалд ахлах байцаагчаас сар бүр биечлэн үзлэг хийж хэвшүүлсний зэрэгцээ харуулын цагдаагийн пост дээр лацны бүртгэлийн дэвтэр нээж, шүүхийн шүүгч, захиргааны ажилтнууд ажил тарах бүртээ харуулын цагдаад хаалгаа лацдаж хүлээлгэж өгч, лацны бүртгэлийн дэвтэрт өөрсдөө бичдэг, энэхүү бүртгэлтэй өглөө бүр шүүхийн тамгын газрын дарга, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн ахлах тогтмол танилцдаг ажлыг хэрэгжүүлж байна

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

-Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн

2017 оны 01-р улиралд 4 алба хаагч арга хэмжээ авагдаж байсан бол 2018 онд 5 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь өмнөх оны мөн үеээс 0.7 хувиар буурсан байна.

Сахилга ёс зүйн зөрчлийг хэлбэрээр нь ангилахад ажлын хариуцлага алдсан 2, архидан согтуурсан 2, Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлөөр нь дүгнэлт хийхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, албандаа хандах хандлага сул байгаагаас нийт 5 алба хаагч арга хэмжээ авахуулсан байна. Арга хэмжээ авахуулсан алба хаагчдыг албан тушаалаар нь ангилхад ахлагч 5 алба хаагч байна. Сахилга ёс зүйн зөрчлийг дотоод хяналт шалгалтаар 5 зөрчлийг илрүүлэн хариуцлага тооцсон.

Сахилгын арга хэмжээний төрлөөр нь ангилахад сануулах сахилгын шийтгэлээр сануулах сахилгын шийтгэлээр 2 ахлагч, албан тушаалын үндсэн цалин хасах сахилгын шийтгэлээр 2 ахлагч, албанаас халах сахилгын шийтгэлээр 1 ахлагч албан тушаалтай алба хаагч байна. Зөрчил гаргасан алба хаагч нарыг албан тушаалаар нь эрэмбэлвэл сум дахь цагдаа-3, харуулын цагдаа-1, жижүүрийн цагдаа-1 тус тус арга хэмжээ авагдсан байна.

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт 2 албаны шалгалтыг 2 алба хаагчид холбогдуулан явуулсан байна. Үүнээс 2 алба хаагчийн албан тушаалын үндсэн цалинг хасаж шийдвэрлэсэн.

Сахилгын зөрчил гаргаж байгаа шалтгаан нөхцлийг судлан дахин гаргуулахгүй байх чиглэлээр холбогдох хууль, дүрэм шинээр батлагдан гарч байгаа журмуудаар алба хаагч нарт сургалт, мэдээлэл хийн ажиллаж байна. Зөрчил дутагдал гаргасан алба хаагч нартай ярилцлага хийхэд өөрсдийн хайхрамжгүй байдал, ямар нэгэн зүйлд хөнгөмсгөөр найдсанаас үндсэн шалтгаанууд тогтоогдож байна.

- Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдаас-1
- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас-4

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар цагдаагийн газраас гэмт хэрэгт холбогдож ял шийтгэгдсэн алба хаагч байхгүй байна.

Бүх шатны тасгийн дарга, ахлах албан тушаалтны манлайлал хангалтгүй, дарга, ахлахууд ажлын гүнд орж, алба хаагч нэг бүрийнхээ ажлыг хянаж шалгадаггүй, тэднийг сургаж дадлагажуулах ажил шаардлагын хэмжээнд хүрээгүй, удирдлагаас өгч байгаа үүрэг даалгаварт ач холбогдол өгч ханддаггүйгээс алба хаагчдын ажил жигд биш байгаагаас сахилгын зөрчил, дутагдал буурахгүй байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг төлөвшүүлэх, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлж буй зорилго зорилтын хүрээнд бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, ёс зүйтэй алба хаагч байх төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөх, алба хаагч бүр сахилга ёс зүйн зөрчил дутагдалд холбогдохгүй байх үүднээс тус Цагдаагийн газрын алба хаагч нарын 2018 оны нэгдүгээр улирлын Сахилга хариуцлагын зөвлөгөөнийг төвийн нийт алба хаагчдыг хамруулан сургалт соён гэгээрүүлэх ажлын хүрээнд зохион байгууллаа.

2018 оны 01-р улирлын байдлаар дутагдлаар албанаас халагдсан алба хаагч 1 байна.

Газрын хариуцлагатай эргүүлд тасаг албадын дарга, ахлах нарыг өдөр тутам болон баяр ёслол, сургалт, цуглааны үеэр газрын даргын баталсан тусгай хуваарийн дагуу удирдлагаас үүрэгжүүлэн ажиллуулж, алба хаагчдын ажлын сахилга хариуцлагад тавих дотоодын хяналт шалгалтыг тогтмолжуулан ажиллаж байна.

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар ёс журам сахиулах эргүүлд ажилласан алба хаагчдын бичсэн хоногийн рапортоор газрын даргаас хийсэн цохолтын биелэлтийг гаргаж нэгтгэн танилцуулсан.

Алба хаагчдын албаны дүрэмт хувцас болон албаны тээврийн хэрэгсэлд тамхи татаж буй байдал, ЦБҮАЖ /код 924/-ын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд долоо хоног бүрийн Даваа, Баасан гаригуудад нийт 4 удаагийн хяналт шалгалтыг сахилга ёс зүйн зөвлөлийн алба хаагчид хуваарийн дагуу хийж, илтгэх хуудсаар хийсэн ажлаа газрын даргад, илрүүлсэн зөрчлийн талаар өглөөний яриан дээр танилцуулан ажиллаж байна.

Цагдаагийн алба хаагчдын гаргасан алдаа дутагдалд дүгнэлт хийж тасгийн дарга, ахлах албан тушаалтан, төрийн бус байгууллагатай хамтран дараах сургалтуудыг зохион байгуулсан.

2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр буюу “Мягмар” гарагийн сургалтын цагаар батлагдсан төлөвлөгөөний дагуу тус цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Оюунгэрэл “**Зөрчлийн тухай хууль**”, “**Гэр бүлийн харилцаа**” сэдвүүдээр **60** алба хаагчид **1** цаг **30** минутын сургалтыг орж, 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 9/53 дугаартай албан бичгээр Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Арсланхуягаас ирүүлсэн “**Гэмт хэргээс урдчилан сэргийлэх тухай хууль**”-ийг алба хаагчдаараа судлуулахаар ирүүлсэнийг уншиж сонсгон гэрийн даалгаварт өгч судлуулахаар даалгасан. 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн Д.Баярмаа “**Шинээр батлагдсан багц хуулийн талаар мэдээлэл**”, Хөдөлмөр нийгмийн халамжийн газрын Халамжийн хэлтэсийн дарга Б.Нямдорж “**Шинээр батлагдсан Халамжийн тухай хууль**”, Скайтел Булган аймаг дахь салбараас шинээр гаргасан ажлын санал”-ыг тус тус 64 алба хаагчид 2 цагийн хугацаанд танилцуулсан.

2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр аймгийн шүүхийн Эвлэрүүлэн зуучлах албаны шүүгч “**Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, гэр бүлийн харилцаа**” сэдэвт сургалтыг 60 алба хаагчид 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Мөн цагдаагийн газрын алба хаагч нарыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-205 / бие даан судлуулахаар гэрийн даалгаварт өгч тэстийн шалгалтаар болон сургалтын дэвтэр хөтөлсөн байдлаар нь дүгнэсэн.

2018 оны 01 дүгээр улиралд цагдаагийн газрын алба хаагчдаас 2 удаа тестийн шалгалт авч, албаны сургалтын дэвтэрийг 3 удаа шалган тестийн шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан 12 алба хаагчийн цалинг 5 хувь, сургалт тасалсан 6 алба хаагчийн цалинг 10 хувь, сургалтын дэвтэрт хангалтгүй тэмдэглэл хөтөлсөн 5 алба хаагчийн цалинг 5-15 хувь үр дүнгээр нь улирлын байдлаар хасаж үүрэг чиглэл өгсөн.

2018 оны 1 дүгээр улиралд тус газрын сургагч багш нараас давхардсан тоогоор 301 алба хаагчид 8 цагийн сургалтыг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран давхардсан тоогоор 404 алба хаагчид 7 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

-Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлага /өсөлт, бууралт тоо хувиар/

2018 оны 03 дугаар сарын байдлаар 5 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан байна. Үүнээс сануулах 2 алба хаагч, албан тушаалын үндсэн цалин хасах 2 алба хаагч, албанаас халах 1 алба хаагч арга хэмжээ авагдсан нь урьд оны мөн үеэс 0.7 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Сахилга ёс зүйн зөрчлийг хэлбэрээр нь ангилахад ажлын хариуцлага алдсан 3, архидан согтуурсан 2 алба хаагч байна.

Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлөөр нь дүгнэлт хийхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, албандаа хандах хандлага сул байгаагаас нийт 5 алба хаагч арга хэмжээ авахуулсан байна. Арга хэмжээ авахуулсан алба хаагчдыг албан тушаалаар нь ангилахад ахлагч 5 алба хаагч байна.

Сахилга ёс зүйн зөрчлийг дотоод хяналт шалгалтаар 5 зөрчлийг илрүүлэн хариуцлага тооцсон.

Тус газрын алба хаагчдаас 2018 оны 01 дүгээр улирлын байдлаар зөрчил заагдаж прокурорын шаардлага аваагүй болно.

-Алба хаагчдыг мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт /ашигласан техник/

Цагдаагийн газрын 2018 оны Албаны сургалтыг зохион байгуулах 5 бүлэг, 11 заалттай төлөвлөгөө, 104 цаг сэдэвтэй календарчилсан төлөвлөгөөг **Цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дугаар сарын 05 өдрийн А/02 дугаар тушаалаар** батлан сургалтын нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нийт бие бүрэлдэхүүнийг буюу **104** алба хаагчийг хамруулан амжилттай зохион байгуулсан.

2018 оны хичээлийн жилийн нээлтийн үеэр анхны сургалтыг Орхон аймгийн Ш.Отгонбилэгийн нэрэмжит Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш сурган хүмүүжүүлэх ухааны доктор, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны Орхон аймаг дахь салбарын тэргүүн, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны нарийн бичгийн дарга Б.Энхцэцэгийг урьж **“Харилцааны өөрийгөө илэрхийлэх чадвар”** сэдэвт 2 цагийн сургалтанд 104 алба хаагч хамрагдсан нь Цагдаагийн Ерөнхий Газрын зорилтын **“Ёс зүйг дээшлүүлэх”** гэсэн шалгуур үзүүлэлтийг ханган ажиллахад алба хаагчдын **ухамсарт** нөлөөлсөн сургалт болсон.

2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр буюу **“Мягмар”** гарагийн сургалтын цагаар батлагдсан төлөвлөгөөний дагуу тус цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Оюунгэрэл **“Зөрчлийн тухай хууль”**, **“Гэр бүлийн харилцаа”** сэдвүүдээр 60 алба хаагчид 1 цаг 30 минутын сургалтыг орж, 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 9/53 дугаартай албан бичгээр Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Арсланхуягаас ирүүлсэн **“Гэмт хэргээс урдчилан сэргийлэх тухай хуул”**-ийг алба хаагчдаараа судлуулахаар ирүүлсэнийг уншиж сонсгон гэрийн даалгаварт өгч судлуулахаар даалгасан. 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр тус цагдаагийн газрын Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Ариунчимэг **“Сургалт зохион байгуулах арга зүй, power point программ дээр мэдээлэл бэлтгэх аргачлал”** сэдэвт сургалтыг 58 алба хаагчид 1 цаг 30 минутын сургалтыг орж тестийн шалгалт авсан. 2018 оны 01 дүгээр сарын 30-ны Аймгийн онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах ахлах мэргэжилтэн, онцгой байдлын ахмад Чинзориг ирж **“Гамшгаас урдчилан сэргийлэх”** чиглэлээр зөвлөгөө зөвлөмж өгсөн.

2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн Д.Баярмаа **“Шинээр батлагдсан багц хуулийн талаар мэдээлэл”**, Хөдөлмөр нийгмийн халамжийн газрын Халамжийн хэлтэсийн дарга Б.Нямдорж **“Шинээр батлагдсан Халамжийн тухай хууль”**, Скайтел Булган аймаг дахь салбараас шинээр гаргасан ажлын санал"-ыг тус тус 64 алба хаагчид 2 цагийн хугацаанд танилцуулсан.

2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр аймгийн шүүхийн Эвлэрүүлэн зуучлах албаны шүүгч **“Эвлүүлэн зуучлах ажиллагаа, гэр бүлийн харилцаа”** сэдэвт сургалтыг 60 алба хаагчид 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр тус газрын мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлаха дэслэгч Т.Мөнхбат **“Санд ажиллах аргачлал, заавар”** сэдэвт сургалтыг 54 алба хаагчид 1 цагийн сургалтын орж алба хаагчдаар дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Мөн аймгийн нэгдсэн эмнэлэгийн доторын их эмч А.Наранхүү **“Эрүүл зөв хооллолт, анхны суурь тусламж”** сэдэвт 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тус газрын сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батмөнх **“Уур, бухимдал”** сэдэвт сургалтыг 62 алба хаагчид 2 цагийн хугацаанд зохион байгуусан.

2018 оны 01 дүгээр улиралд цагдаагийн газрын алба хаагчдаас 2 удаа тестийн шалгалт авч, албаны сургалтын дэвтэрийг 3 удаа шалган тестийн шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан 12 алба хаагчийн цалинг 5 хувь, сургалт тасалсан 6 алба хаагчийн цалинг

10 хувь, сургалтын дэвтэрт хангалгүй тэмдэглэл хөтөлсөн 5 алба хаагчийн цалинг 5-15 хувь үр дүнгээр нь улирлын байдлаар хасаж үүрэг чиглэл өгсөн.

2018 оны 1 дүгээр улиралд тус газрын сургагч багш нараас давхардсан тоогоор 301 алба хаагчид 8 цагийн сургалтыг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран давхардсан тоогоор 404 алба хаагчид 7 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

-Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил арга хэмжээ

2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр тус цагдаагийн газрын алба хаагч, ажилтануудын бие бялдарыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор биеийн тамирын арга хэмжээний нээлтийг **Аймгийн онцгой байдлын газрын спорт заалыг ашиглах зорилгоор Онцгой байдлын газрын даргатай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа З.Гомбо** үг хэлж, биеийн тамир, спортын амжилт хүсч алба хаагчдыг багийн системд хуваарилан нийт **41** алба хаагчийг оролцуулан **“Гар бөмбөг”-ийн** тэмцээнийг зохион байгуулсан нь хамт олны урмыг сэргээсэн арга хэмжээ болсон.

Цаашид Онцгой байдлын газрын зааланд **7** хоног бүрийн **“Мягмар”** гарагийн 18 цагаас алба хаагч, ажилтануудын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, тэмцээн уралдаан зохион байгуулдаг уламжлалыг үргэлжлүүлэн зохион байгуулахыг **“Биеийн тамир, спортын хамтлагт”** үүрэг болголоо.

Цагдаагийн газрын Соёл, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Замын цагдаагийн тасгаас санаачлан “Орхон голын жавар 2018” цасны баярын арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд тасгуудын хооронд Олс талалт, Цасны сумо, Хөгжөөнт буухиа тэмцээнүүдийг зохион байгуулан тэмцээн тус бүрт тэргүүн байрт шалгарсан тасаг, тамирчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр нийт эрэгтэй алба хаагч, ажилтан нарт Монгол улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 97 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн хүлээн авалт зохион байгуулсан.

-Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байдал

Аймгийн хэмжээнд 2018 оны 1-р улиралд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр телевизээр 2 удаа 5 минутын, радиогоор 15 удаа 36 минутын нэвтрүүлэг, сэрэмжлүүлэг мэдээ, сонин хэвлэлээр 3 удаа нийтлэл, мэдээллийг иргэдэд хүргэн сурталчилж ажилласан.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэн гарсан гэмт хэрэг, зөрчил, түүний илрүүлэлт, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг 14 хоног тутамд даваа гарагийн аймгийн удирдлага, захирал, эрхлэгч нар оролцсон шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж, “Булганы мэдээ” сонин, МОНЦАМЭ агентлагийн сурвалжлагч, аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албанд 7 хоногийн хэрэг, зөрчлийн мэдээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиосон ажлын мэдээллээ тогтмол өгч нийтлүүлэн, аймгийн [Bulgan police gov.mn](http://Bulgan.police.gov.mn), вэб сайт, “Булган аймгийн Цагдаагийн газар” facebook хуудаст хэрэг зөрчлийн танилцуулга, камерын мэдээ, зохиосон ажлын тухай мэдээлэл, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, шторк зэрэг 68 мэдээлэл тухай бүр нь оруулж иргэдэд сурталчилан ажилласан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хуулиа мөрдье”, “Сэрэмжилье нэгдье”, “Хуулийн хэрэгжилт” арга хэмжээний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр tv9 телевизээр 2 удаа, радиогоор 15 удаа, сэрэмжлүүлэг мэдээ, сонин хэвлэлээр 2 удаа сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүргэн сурталчилж ажилласан. Мөн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид анхаарах сэрэмжлүүлэг мэдээллийг аймгийн удирдлага, захирал, эрхлэгч нар оролцсон шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж, “Булган аймгийн Цагдаагийн газар” facebook хуудас, сумдын Цагдаагийн хэсгийн цахим хуудсаар 54 мэдээлэл, 11 төрлийн сэрэмжлүүлэг шторк тухай бүр нь оруулж иргэдэд сурталчиллаа.. Юнителын “Web2SMS” үйлчилгээгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээг аймгийн удирдлага, агентлаг байгууллагуудын дарга, эрхлэгч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхлэгч, ажилтан, 16 сумын Засаг дарга, аймгийн ИТХ-ын тэргүүлэгч, багийн Засаг дарга нар нийт 164 хүнд 3 удаа мессэжээр хүргүүлэн ажилласан.

“Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн ирүүлсэн богино хэмжээний 8 видео, 21 контентуудыг цагдаагийн газрын болон 6 албан байгууллагын хүлээлгийн танхимын мэдээллийн хэрэгслээр байнгын давтамжтай явуулж, Цагдаагийн газрын болон алба хаагчдын /нийт 97 алба хаагчийн/ хувийн цахим хуудаст татаж иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулсан.



-Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

Цагдаагийн Ерөнхий газрын 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 4б/658 албан бичгээр ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын зөвлөмжтэй танилцаж. Цагдаагийн газрын 2018 оны авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газрын нийт алба хаагчдад “Авлига, ашиг сонирхлын тухай ойлголт”, “Авлигын эсрэг хууль, тогтоомжийн тухай ойлголт” сэдвээр 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 1 цагийн сургалт орж, 96 алба хаагчаас тест боловсруулан шалгалт авахад 62 алба хаагч 80-100, 29 алба хаагч 70-80, 5 алба хаагч 60-70 хувьтай дүгнэгдсэн.

2. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулж үр дүнг тооцож 3 алба хаагчийг урамшуулан ажилласан.

3.Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд Цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүй, авлига, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг Булган аймгийн Цагдаагийн газрын 94333102 дугаарын тусгай утсаар 24 цагаар хүлээн авч ажиллаж байгаа талаар иргэдэд сурталчилах ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Дөрөв:Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний чиглэлийн талаар

в:Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний чиглэлийн талаар

-Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээ

Тус газар нь 2018 оны 1-р улиралд 458164.0 мянган төгрөгийн төсөвтэй 1500,0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэлээр 458164.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 712.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 52.5%-иар орлогын төлөвлөгөө дутуу, нэмэлт санхүүжилтээр нийт 2945.0 мянган төгрөгийн санхүүжилт авч малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн үеийн хамгаалалт болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулж ажилласан байна.

Үйл ажиллагааны орлогыг эрүүлжүүлэх байр, саатуулах байрны төлбөрийн орлогоос бүрдүүлдэг бөгөөд эрүүлжүүлэгдэж, баривчлагдаж байгаа хүмүүсийн тоо эрс буурсан.

Төсвийн санхүүжилт, зардлын гүйцэтгэлийн задаргааг хүснэгтээр авч үзвэл: /мян төг/

Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
ᠣᠨᠠᠭᠠᠨ ᠴᠠᠳᠠᠭᠠᠨ ᠠ ᠠ	459664,0	439645,9	20018,1	95,6%
ᠣᠠᠭᠠᠨ ᠰᠣᠨᠬᠡᠭᠡᠰᠡᠨ ᠠᠬᠤ	369542,7	360899,2	8643,5	97,7%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	242893,5	238815,2	4078,3	98,3%
ᠠᠨᠠᠭᠠᠨ	126649,2	122084,0	4565,2	96,4%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	8191,2	8012,7	178,5	97,8%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	38799,6	36944,5	1855,1	95,2%
ᠣᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	27508,5	24574,9	2933,6	89,3%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	3507,6	3443,0	64,6	98,1%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	6755,1	2416,0	4339,1	35,7%
ᠣᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	4569,9	3104,5	1465,4	67,9%
ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ	289,3		289,3	-

журмын дагуу цаг хугацаанд нь холбогдолтой мэдээллүүдийг бүрэн оруулж хэвшээд байна. Шилэн дансны тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийг хангаж Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны “Төсөв гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “Бусад” гэсэн 3 дэд цэсэнд тухай бүр, сар бүр, улирал, хагас, бүтэн жилээр тус бүр оруулах хугацаагаар ангилан уг хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг тогтмол оруулна гэсний дагуу “Шилэн данс”-ны цахим сүлжээнд 2018 оны 1-р улирлын байдлаар тухай бүрд оруулах 8 мэдээлэл, сар бүр оруулах 2 мэдээлэл, улирал бүр оруулах 1 мэдээллийг цаг тухай бүрд нь оруулж мэдээллийг баяжуулан бүртгэсэн байна. Тухайн мэдээллийг оруулахдаа тухай бүрд нь үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх, мэдээлэл ойлгомжтой байх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх гэсэн шилэн дансны зарчмийг хангаж ажилласан.

Аудитын чиглэлээр 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн. Мөн менежментийн захидалдаа тухайн сарын төсөв хүрэлцэхгүйгээс бүлэг хооронд зардлыг шилжүүлэн зарцуулсан нь санхүүгийн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлөх 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр

Цагдаагийн Ерөнхий Газрын Санхүү аж ахуйн албаны даргын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 6/450 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр Хангалт үйлчилгээний төвийн урьд талд байрлах “Цагдаа-Амгалан” хотхоны хоёр дахь ээлжийн 270 айлын орон сууцанд тус Цагдаагийн газраас 9 алба хаагч санал өгсөнийг ирүүлсэн хавсралт хүснэгтийн дагуу судалгааг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 34/04-563 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Цагдаагийн газрын даргын 03 дугаар сарын 21-ний өдрийн 34/01-461 тоот албан бичгээр 128 алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулахаар материалыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн ажилласан.

-Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Булган аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран тус Цагдаагийн газрын алба хаагчдад элэгний “В”, “С” вирусын шинжилгээг авч, элэг хамгаалах 1 дүгээр тунгийн вакцинд хамруулан ажиллаж 3 алба хаагчийг “С” вирусын эмчилгээнд хамруулсан.

Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Шүд эрүүл бол бие эрүүл” сэдэвт сургалтыг төвийн алба хаагчдын дунд зохион байгуулж, үзлэг, оношилгоо хийж, 21 алба хаагчийг шүдний эмчилгээнд хамруулахаар болсон. Мөн Цусны төвтэй хамтран алба

хаагчдыг цусны шинжилгээнд хамруулан сайн дураар донорын цус өгөхөөр 23 алба хаагч хамрагдсан.

-Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар

а: Цагдаагийн газрын дотоод аюулгүй хангах чиглэлээр

2018 оны 1 дүгээр улиралд цагдаагийн газарт мэдүүлэг авах, таньж олуулах өрөөг шинээр засварлан тохижуулж ажилласан.

Мэдүүлэг авах өрөөн орох эрх бүхий алба хаагч нарт мэдүүлэг авах өрөөнд ажиллах талаар сургалт орж ажилласан.

Эрүүгийн цагдаагийн тасгийн гадна хаалгыг тусгай картаар онгойх зориулалт бүхий соронзон түгжээг байрлуулсан.

Цагдаагийн газрын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын 1 давхарын галт зэвсэг болон мөрдөгч нарын албан өрөөний цонхыг төмөр рещотка хийж ажилласан.

Цагдаагийн газрын гадна шинээр шөнийн хараатай 2 камер байрлуулан эд мөрийн баримт хадгалах өрөө болон Цагдаагийн газрын автогражийг 24 цагийн бүрэн хяналтанд авч ажиллаж байна.

б: Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/248 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-909/-ын дагуу 2018 оны 01 дүгээр улирлын байдлаар Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Б.Булгантамирыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/180 дугаар тушаалаар Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн Баяннуур сум дахь зохицуулагчаар дэвшүүлэн томилсон. Мөн Хутаг-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн тасгийн даргын сул орон тоо, Могод сумын хэсгийн төлөөлөгчийн сул орон тоонд 2 алба хаагчийг дэвшүүлэн томилуулахаар материалыг Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн газрын дарга, удирдлагуудаас дэмжин Их засаг олон улсын их сургуулийн эрх зүйн магистрт 6 алба хаагчийг суралцуулан 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдөр амжилттай төгсөж ромбо, дипломоо гардан авсан.

Ажлын байрны тодорхойлолтонд заасан үндсэн үүрэгт ажилдаа идэвхи зүтгэл үр, бүтээл гарган ажилласанг нь үнэлж дараах алба хаагч нарыг шагнаж урамшуулсан байна. Үүнд:

ТӨРИЙН ШАГНАЛ

1. “Цэргийн хүндэт” тэмдэг Хангал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Батбилэг шагнагдсан байна.

Цагдаагийн газрын сул орон тооны захиалгыг ЦЕГ ын хүний нөөц сургалтын хэлтэст 1 удаа явуулан цагдаагийн байгууллагад орох хүсэлт гаргасан 21 иргэний материалыг хүлээн авч, 17 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын /төрийн албаны салбар

зөвлөл/ Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлэн шалгалт оруулж, шалгалтанд тэнцсэн 6 иргэнийг нөөцөд бүртгэн 2 иргэнийг цагдаагийн газрын сул орон тоонд томилон ажиллуулсан.

Ажлын байрны сонгон шалгаруулалтыг явуулахдаа Цагдаагийн газрын Face book, вэб сайт, Ард ТҮ, Сайхан Монгол ФМ-ээр олон нийтэд сурталчлан зарлан мэдээлж, бүртгүүлсэн иргэнийг судалж, сонгох ажлыг зохион байгуулан материалыг ЦЕГ-ын хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлэн ажилласан.

Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилох, сэлгэн ажиллуулах ажиллагаанд тавих шаардлагыг өндөрсгөх бодлого баримталж, ялангуяа албан тушаал дэвшүүлэн томилж байгаа алба хаагчийг судалж сонгох, үүнээс өмнө удирдах албан тушаалд сургаж дадлагажуулах бэлтгэх ажлыг хийж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл баримтлан ажиллаж байна.

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар байгууллага дотроо 8, бусад цагдаагийн газарт 3 алба хаагч, бусад цагдаагийн газраас 2 алба хаагч шилжин ирж ажилласан.

2018 оны 01 дүгээр улирлын байдлаар Булган аймаг дахь цагдаагийн газарт нийт 5 алба хаагч шинээр томилогдон ажилласан.

2017 оны Хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхолын мэдүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны дотор нийт 60 офицер алба хаагчдаар бөглүүлэн ажилласан.

2018 онд шинээр томилогдсон болон шилжилт хөдөлгөөн хийсэн 8 алба хаагчийн ХАСХОМ бөглүүлэн ажилласан.

2017 оны 01 дүгээр улиралд 4 алба хаагч арга хэмжээ авагдаж байсан бол 2018 онд 01 дүгээр улиралд 5 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь өмнөх оны мөн үеээс 0.7 хувиар өссөн байна.

Үүнээс сануулах 2 алба хаагч, албан тушаалын үндсэн цалин хасах 2 алба хаагч, албанаас халах 1 алба хаагч арга хэмжээ авагдсан нь урьд оны мөн үеэс 0.7 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Сахилга ёс зүйн зөрчлийг хэлбэрээр нь ангилахад ажлын хариуцлага алдсан 3, архидан согтуурсан 2 алба хаагч байна. Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлөөр нь дүгнэлт хийхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, албандаа хандах хандлага сул байгаагаас нийт 5 алба хаагч арга хэмжээ авахуулсан байна. Арга хэмжээ авахуулсан алба хаагчдыг албан тушаалаар нь ангилахад ахлагч 5 алба хаагч байна. Сахилга ёс зүйн зөрчлийг дотоод хяналт шалгалтаар 5 зөрчлийг илрүүлэн хариуцлага тооцсон.

Зөрчил гаргасан алба хаагч нарыг албан тушаалаар нь эрэмбэлвэл хамгаалалтын цагдаа-1, жижүүрийн цагдаа-1, сум дахь цагдаа-3 тус тус арга хэмжээ авагдсан байна.

2018 оны 01-р улирлын байдлаар 2 албаны шалгалтыг 2 алба хаагчид холбогдуулан явуулж, 2 алба хаагчийн албан тушаалын үндсэн цалинг хасаж шийдвэрлэсэн.

Тус газрын Хүний нөөцийн мэргэжилтэнд бүртгэлтэй байгаа 64 ахлагч, 4 энгийн алба хаагчийн хувийн хэрэгт “Алба хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журам” /код 936/-д заасны дагуу тогтмол баяжилт хийн ажиллаж байна. Мөн цагдаагийн газрын Хүний нөөцөд 132 алба хаагчдын сангийн баяжилтыг 95 хувьтай хийж ажилласан. Алба хаагч шинээр томилогдох, шилжилт хөдөлгөөн хийх, цагдаагийн ерөнхий газар болон сургалт

дадлагын төвд сургалтанд хамрагдаж байгаа алба хаагч нарын мэдээллийг тухай бүр нь санд оруулан баяжилт хийсэн. Офицер алба хаагч нарын хувийн хэрэгт тухай бүр нь баяжилт хийн алба хаагч нарын материалыг албан тоотойр Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдын бэлэн байдлыг хангуулах чиглэлээр “Ц-111” дохиогоор хэсэгчилсэн болон нийт давхардсан тоогоор 6 удаа түргэн цугларалт авч, албаны болон хувийн бэлэн байдлыг шалгаж жагсаалын бэлтгэл хийлгэж, хоногийн нөхцөл байдлын болон ёс журам сахиулах хариуцлагатай эргүүлийн мэдээлэлд тусган зөрчлийг засуулан ажиллалаа.

Тус газрын нийт алба хаагчдаас зөрчил, дутагдал гаргахгүй, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар баталгаа авсан.

Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр алба хаагч нарт 2015 онд 4 удаа, 2016 онд 3 удаа, 2017 оны жилийн эцсийн байдлаар 1 удаа сургалт орж алба хаагч нарт мэдээлэл хийж ажиллалаа.

Үүнээс:

1. Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон Хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар
2. Шагнал урамшуулал олгох журам
3. Хүний нөөцийн сан гэж юу вэ?
4. Хүний нөөцийн ажлын чиглэл
5. Хүний нөөцийн эрсдлийг бүртгэх чиглэлээр сургалтыг тус тус орсон.

Шинээр томилогдсон алба хаагч нарыг ажилд нь богино хугацаанд сургаж дадлагажуулах чиглэлээр ажлын дадлага туршлагатай олон жил ажилласан ахлах албан тушаалтан нарыг тушаалаар томилон сургаж дадлгажих ажлын төлөвлөгөө гарган Цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллаж байна.

в: Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Авилга, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авах болон харъяалалын бус хэрэг маргаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдох зэрэг ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдсон алба хаагч гараагүй бөгөөд энэ төрлийн албаны шалгалт явуулаагүй байна.

Алба хаагчдыг авилга, албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх талаар бичгээр баталгаа гаргуулан авч “Амлалтын дэвтэр”-т энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохгүй байх талаар бичүүлэн авсан.

Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагч нарт эдийн засгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Т.Баттөр, Эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч З.Итгэлбаяр нар 2 удаа сургалтыг зохион байгуулсан.

Авилгатай тэмцэх газрын шалгалтын хэсгийн зохион байгуулсан сургалтанд алба хаагч нарыг бүрэн хамруулсан.

Алба хаагчдын сарын хэрэгцээ шаардлагыг үндэслэн сарын бүрийн 10-ны дотор урьдчилгаа цалин олгож, 23-ны дотор сарын үлдэгдэл цалинг тооцон олгосноор хэрэглээний мөнгөний хараат байдалд орохоос урьдчилан сэргийлж байна.

Албан үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хэвийн аюулгүй үйл ажиллагааг явуулах, эрсдэлгүй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор алба хаагч нарыг ЦЕГ-ын СААА-аас Монгол даатгалын газарт осол гэмтлээс урьдчилан сэргийлэх даатгалд бүрэн хамруулсан.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тасаг албадын дарга нарт чиглэл өгч эрсдэлд өртөж болзошгүй алба хаагчийн нэрсийг гаргуулан эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгуулан ажиллаж байна.

г: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Тус цагдаагийн газрын албан бичиг болон алба хаагчдын хооронд мэдээлэл солилцоход хялбар болон мэдээллийн нууц алдагдахаас сэргийлж алба хаагч тус бүрийн outlook хаягаар тус газрын Холбоо Мэдээллийн инженер нэвтэрч, мэдээллийг сүлжээнд архивлан ажиллаж байна. Цагдаагийн газрын нарийн бичгийн mail хаягаар Цагдаагийн байгууллагын албан бичиг их хэмжээгээр илгээгдэх, хүлээн авч байгаатай холбогдон ирсэн, явуулсан албан бичгийг сүлжээнд архивлан ажилласан.

ЦЕГ-ын МХТТ-ийн цагдаагийн дотоод сүлжээний server-тэй холбож Domain -д бүртгүүлж ажиллаж байна. /Bulgan-001-Нарийн бичиг/ /Bulgan -002- Хүний нөөц/ /Bulgan -003- Холбоо Мэдээллийн инженер/ Bulgan -004 Цагдаагийн газрын Жижүүрийн Шуурхай Алба/ Bulgan -005 ЗЦТ-ийн дарга/, /Хэрэг бүртгэх тасгийн ахлах/, /МБТ-ийн дарга/, /Мэдээлэл судалгааны ахлах/, /НХЖХТ-ийн ахлах/, /НХЖХТ-ийн дарга/ зэрэг алба хаагчдын компьютерыг ЦЕГ-ын МХТТ-ийн сервирт холбож сүлжээг ISOLATION болгож ажилласан.

ЦЕГ-ын МШУТ-с санаачилан хийж байгаа цагдаагийн байгууллагын телефон утасны дугаарлалтыг 7019.... дугаарлалт руу шилжүүлэн нийт 16 ширхэг дугаар ажиллаж байна.

ЦЕГ-ын Холбооны төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу Булган аймаг дахь Цагдаагийн газрын алба хаагчид хэт богино долгионы станцаар торонд харилцах дуудлага болон удирдлагаас өгөх команд харилцах кодыг шинэчилж гаргасан.

Алба хаагчдын ашиглаж байгаа нийт компьютерт өдөр тутам мэдээлэл устах болон гэмтэхээс сэргийлэх тог цахилгааны өөрчлөлтөөс шалтгаалж гэмтэх магадлалтайг алба хаагч бүрт сануулах, сэрэмжлүүлэх зорилгоор алба хаагчдын “Face book групп”-д мэдээллийг тогтмол байршуулж байна.

Цагдаагийн байгууллагад шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэглэхэд тохиромжтой төхөөрөмжийг судлан үнийн судалгаа гаргаж удирдах албан тушаалтанд танилцуулж ажилласан.

Мэдүүлэг авах өрөөний 2 ширхэг компьютер, 4 ширхэг хяналтын камер, 2 ширхэг принтер, 2 ширхэг тог баригч, камерын төхөөрөмжүүдийг угсарч хэвийн ажиллагаанд оруулж удирдлагуудад танилцуулж хүлээлгэж өгсөн.

Эд мөрийн баримт, граж, склад зэргийг хянах 3 ширхэг камер суурилуулан ЖША-ны хяналтын дэлгэцэнд хяналтыг холбож ажилласан.

д: Санхүү /төсвийн хөрөнгө/ -ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Санхүүгийн аюулгүй байдлыг хангахад төсвийн зарцуулалт, ашиглалтын талаар санхүүгийн тайланг тавьсан. Алба хаагч нараас ямар нэгэн санал хүсэлт

гараагүй. Санхүүгийн ил тод байдлыг ханган байгууллагын веб сайт, фэсбүүк хуудас, шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн жилийн төсөв, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ, өр, авлагын мэдээ, төлбөрт үйл ажиллагааны орлого 5 сая төгрөгнөөс дээшхи гүйлгээг тухай бүр байршуулан ил тод байдлыг хангаж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасныг, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэн Цалин олголт болон санхүү, төсвийн зарцуулалтын талаар тухай бүр нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган веб сайт, фэсбүүк, цахим хуудсанд тавиулан ажиллаж байна.

е: Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, агсамжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Албаны галт зэвсэг тусгай хэрэгслийг 2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/30 тоот, 2017 оны 12 сард нийт ЦБҮА-ны код-136.4.2.-д заасаны дагуу 2 удаа цагдаагийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан галт зэвсгийн тооллогыг явуулан ажиллаж байна. Албаны зэвсэг дагалдах хэрэгслийг ЖА-ны өрөөнд тусгайлсан 3 төмөр сейфинд ПМ-61, АКМ-7, СВД-1, Жад-6, кабер-44, сүмбэ-21, 1)Л- 12-2, дохионы буу-2, хийн буу-3, АКМ маказин 7 ширхэгийг хийж лацдан хариуцлагатай зохицуулагчийн хяналтад хадгалж байгаа ямар нэг галт зэвсэг, хийн буу дутсан зөрчил гараагүй бүрэн тоологдсон.

ЦЕГ-ын даргын 2014 оны №239 дүгээр тушаалын дагуу галт зэвсгийг сейфнээс гаргаж өгөх үед цагдаагийн алба хаагч өөрийн хариуцсан зэвсгийг тусгай бүртгэлийн дагуу эзэмших картын хамт НХЖХАХАхлах байцаагчид өгөн дараагийн ажилд шилжин орох мөн зэвсгийг эргэж өгөх үед цэвэрлэгээ үйлчилгээ бүрэн бүтэн байдлыг шалгуулан гарын үсэг зуран хүлээлгэн өгөн ажиллаж байна.

Зэвсэг хэрэглэлийн хадгалалт, хамгаалалт, тавьж олгох, ашиглалт зарцуулалтанд хяналт тавьсан бүртгэлийг ЦЕГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 239 дүгээр тушаалыг баримтлан НХЖХАХАхлах байцаагч хариуцан хөтлөж өдөр тутам жижүүрийн офицерууд лацыг нүд үзэн хүлээлцэж хоногийн нөхцөл байдлын рапортод тусган ажиллаж байгаа ба ямар нэг зөрчил дутагдал илрээгүй.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн Б/631 дүгээр тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дрга, цагдаагийн дэд хурандаа Ө.Нармандах нь 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын газрын тусгай хамгаалалтын хэлтсийн даргаар томилогдон тул цагдаагийн газрын албаны галт зэвсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр албаны галт зэвсгийг хүлээлцэн ажиллав.

Цагдаагийн газрын албаны галт зэвсэг дагалдах хэрэгслийг ЖА-ны өрөөнд тусгайлсан 3 төмөр сейфинд ПМ-61, АКМ-7, СВД-1, Жад-6, кабер-44, сүмбэ-21, 1)Л- 12-2, дохионы буу-2, хийн буу-3, АКМ маказин 7 ширхэгийг хийж лацдан хариуцлагатай зохицуулагчийн хяналтад хадгалж байгаа ямар нэг галт зэвсэг, хийн буу дутсан зөрчил гараагүй бүрэн тоологдсон.

“Сар шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан, шүүхээс хорих ял нь тэнсэгдсэн, ял хойшлогдсон, мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хүмүүст хэсгийн байцаагч, мөрдөгч нараар хувийн хэрэгт баталгааг авч ажиллав.

Мөн “Булганы мэдээ” сонинд сар шинийн баярын бэлтгэл хангах үеэр хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхгүй байх талаарх сэрэмжлүүлэг нийтлүүлэн, аймгийн төвийн алба хаагчид “Тэгш хэм”-ийн системээр хуваарилсаны дагуу 69 алба хаагч нийт 1107 айл өрхөөр орж, баярын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг тарааж, баяр амралтын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын дарга, эрхлэгч нарт 54 албан мэдэгдэл өгч, хэрэгжилтийг нь тооцож ажилласан. Мөн аймгийн ГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр 700 ш сэрэмжлүүлэг хэвлүүлэн худалдааны төв, зах, гүний худаг усан сан, дэлгүүр, шатахуун түгээх станц, банк, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан, иргэдэд мэдээлэл сэрэмжлүүлэг хүргэсэн.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр ажил арга хэмжээ зохиолгохоор алба хаагчдаас 2018 оны 1 дүгээр улиралд 54 албан мэдэгдэл бичиж 45-д хариу авсан бөгөөд хугацаа болоогүй 20 мэдэгдэл байна.

ё: Барилга байгууламж /объект/-ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 429 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын стандарт”-ын хэрэгжилтийг төв орон нутгийн цагдаагийн газар хэлтэс хангуулах чиглэлээр төлөвлөгөө гаргаж биелэлт үр дүнг тооцож ажиллах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 429 дүгээр тушаалаар баталсан байгууллагын стандартыг хангуулах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. Алба хаагчид өөрсдийн албан өрөөнд урсгал засвар хийж өнгө үзэмжийг сайжруулсан.

Барилга байгууламжийг гадны аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх, телекамерын хяналтын систем, дохиолол, шалган нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн 52 дугаарт тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах улсын албаны удирдлагын бүтэц”, “Гамшгаас хамгаалах улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварын дагуу Булган аймаг дахь Цагдаагийн газрын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн гаргаж баталуулсан.

Учирч болзошгүй гамшиг аюулын үед байгууллагын эд хөрөнгө, баримт сэлтийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, схем

зураг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан нууцлал аюулгүй ханган ажилласан.

Учирч болзошгүй байгалийн гамшиг осол, газар хөдлөлтийн аюулын үед байгууллагын эд хөрөнгө, баримт сэлтийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, схем зураг боловсруулж, батлуулж хэрэгжүүлэх, сургалт дадлага зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн газрын галын аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдалыг засуулах зорилгоор Онцгой байдлын газрын мэргэжилтэнээр шалгалт хийлгэн “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт”-ийг гаргуулсан. Галын болон бусад гамшиг, ослын үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж Цагдаагийн газрын даргаар батлуулсан. Галын аюулгүй байдлын буланг шинээр хийж Монгол улсын Галын аюулаас хамгаалах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм МN5566:2005 стандартын дагуу багаж хэрэгслийг байрлуулан нөөц бэлтгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн газрын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын конторын алба хаагчид ажлын цаг дуусч ажлаас тарахдаа өрөөний цахилгаан үүсгэвэрийг бүрэн салгаж унтраан лацыг жижүүрт хүлээлгэн өгч хэвших, алба хаагчдын өрөөний түлхүүрийг хувилан жижүүрийн өрөөнд тусгай хайрцаг саванд хийн ерөнхий жижүүр хариуцан ажиллах ажлын чиглэл үүргийг өгч үүргийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхийг орон тооны ажлын хэсэг болон тухайн өдөр ёс журам сахиулах хариуцлагатай эргүүлд гарч байгаа тасаг албадын дарга, ахлахуудаар биечлэн шалгуулан цахилгаан үүсгэвэрийг салаагүй, өрөөг лацдаж хүлээлгэн өгөөгүй алба хаагчдыг дуудаж ирүүлэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ёс журмын рапортонд оруулан хариуцсан тасгийн дарга нарт зөрчлийг арилган дахин гаруулахгүй байх талаар цохолт хийн хэрэгжилтийг 14 хоног, сараар жижүүрийн офицероор гаргуулан танилцаж өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаагүй тасгийн дарга нарт ажлын үр дүнгээр хариуцлага тооцох ажлыг хэрэгжүүлэн хэвшүүлснээр энэ төрлийн зөрчлийг бүрэн арилгаад байна.

Тус Цагдаагийн газрын барилга нь 1995 оны 11 сард ашиглалтанд орсон 32,8 м урттай, 12,0м өргөнтэй, 1056 /1188/ ажлын ашигтай талбайтай, 3960м³ барилгын эзэлхүүнтэй, барилгын галд тэсвэрлэлтийн зэрэг 2, зоорийн давхартай.Цагдаагийн газрын өргөтгөлийн барилгыг барих зайлшгүй шаардлага гарч байгаа тул хөрөнгийг 2016 оны улсын төсөвт оруулж шийдвэрлүүлэх саналуудыг ЦЕГ, Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Онцгой байдлын газрын ахлах мэргэжилтэн хошууч Үүрийнтуяагаар гал түймрийн аюулаас хамтдаа сэргийлье бид яах ёстой вэ? 2 цагийн сургалт хийлгэсэн.

Цагдаагийн газрын алба хаагч нарын өрөөний байршил солигдсон, зарим өрөөний зориулалт өөрчлөгдсөн тул байгууллагын “Байгалийн гамшиг, гал түймэр гарсан үед ажиллах төлөвлөгөө”-нд нэмэлт өөрчлөлт үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Галын аюулгүй байдлын буланг шинээр хийж Монгол улсын Галын аюулаас хамгаалах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм ММ35566:2005 стандартын дагуу багаж хэрэгслийг байрлуулан нөөц элтгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.Цагдаагийн газрын галын аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдалыг засуулах зорилгоор Онцгой байдлын газрын мэргэжилтэнээр шалгалт хийлгэн “Ажлын байрны галын аюулгүй

байдлын дүгнэлт”-ийг гаргуулсан. Гал түймэр гарсан үед алба хаагч нарын гарах аврах гарц, түүнийг заасан тэмдэглэгээнүүдийг шинэчлэн хийж байршуулсан.

Цагдаагийн байгууллагуудын барилга, байгууламжийн аюулгүй ажиллагааны норм, дүрмийг мөрдөж ажиллах, Гамшгаас хамгаалах тухай хууль болон Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажлын хүрээнд Цагдаагийн газрын галын аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдалыг засуулах зорилгоор Онцгой байдлын газрын мэргэжилтэнээр шалгалт хийлгэн “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт”-ийг гаргуулсан .Галын болон бусад гамшиг, ослын үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж Цагдаагийн газрын даргаар батлуулсан.

Цагдаагийн газрын хяналтын камерийн галын дохиолын ажиллагааг 1 удаа шалгаж алба хаагчдын болон техник хэрэгслийн бэлэн байдлыг шалган ажиллалаа.Цагдаагийн газрын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын конторын алба хаагчид ажлын цаг дуусч ажлаас тарахдаа өрөөний цахилгаан үүсгэвэрийг бүрэн салгаж унтараан лацыг жижүүрт хүлээлгэн өгч хэвших, алба хаагчдын өрөөний түлхүүрийг хувиран жижүүрийн өрөөнд тусгай хайрцаг саванд хийн ерөнхий жижүүр хариуцан ажиллах ажлын чиглэл үүргийг өгч үүргийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхийг орон тооны ажлын хэсэг болон тухайн өдөр ёс журам сахиулах хариуцлагатай эргүүлд гарч байгаа тасаг албадын дарга, ахлахуудаар биечлэн шалгуулан цахилгаан үүсгэвэрийг салаагүй, өрөөг лацдаж хүлээлгэн өгөөгүй алба хаагчдыг дуудаж ирүүлэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ёс журмын рапортонд оруулан хариуцсан тасгийн дарга нарт зөрчлийг арилган дахин гаруулахгүй байх талаар цохолт хийн хэрэгжилтийг 14 хоног, сараар жижүүрийн офицероор гаргуулан танилцаж өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаагүй тасгийн дарга нарт ажлын үр дүнгээр хариуцлага тооцох ажлыг хэрэгжүүлэн хэвшүүлснээр энэ төрлийн зөрчлийг бүрэн арилгаад байна.Мөн цагдаагийн газрын 1 дүгээр давхарт байрлах өрөөнүүдийн цонхонд шаардлага хангасан хамгаалалт төмөр хийлгэх талаар судлагаа хийлгэн хамгаалалт төмөр хийлгэх ажлыг 2018 оны 1-р улиралд багтаан зохион байгуулах чиглэл өгөн ажиллаж байна. Камерийн хяналтыг жижүүрийн өрөө, Цагдаагийн газрын даргын архив бичиг хэргийн эрхлэгчийн өрөө, саатуулах байрны өрөө, 1 дүгээр давхарын коридорын хэсгийг бүрэн камержуулан байнгын хяналт тавин ажиллаж байгаа ба байгууллагын гадна, дотно орчинд нэмэгдэл камер тавих судалгааг хийлгэн камержуулах ажлын чиглэл өгөн ажлуулж байна.Алба хаагч болон байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор камерын хяналтаас гадна жижүүрийн офицерыг ажлын цагаар жижүүрийн өрөөний гадна коридорт суулган дарга, удирдлага, алба хаагс нартай уулзахаар ирж байгаа хүмүүсийн бичиг баримтыг шалган бүртгэл хөтлөн оруулдаг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж хэвшээд байна.

Барилгын ашиглалтын төлөв байдлын талаар мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтэнд заагдсан зөрчлийг арилгах чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлж 2017 онд мэргэжлийн байгууллагуудаар дахин дүгнэлт гаргуулж Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад холбогдох танилцуулгыг хүргүүлж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх арга хэмжээ авч Цагдаагийн газрын барилга байгууламжийг мэргэжлийн хяналтын газар холбогдох албан тушаалтантай хамтран ажилласан. Цагдаагийн газрын аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг засуулах зорилгоор онцгой байдлын газрын мэргэжилтнээр шалгалт хийлгэж ажлын байрны газрын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулсан. Мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтэд заагдсан зөрчлийг арилгах чиглэлээр шат дараалалсан арга хэмжээ авч ажилласан. Цагдаагийн газрын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн газрын конторын алба хаагчид ажлын цаг дуусч ажлаас тарахдаа өрөөний цахилгаан үүсгүүрийг бүрэн салгаж унтараан лацыг жижүүрт хүлээлгэн өгч хэвшсэн.

Ашиглалтын явцад илэрсэн эвдрэл гэмтлийг “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар ашиглалтын хугацааны жижиг норм”-ын 2.4-ийн хүснэгт 1-д заасан үр ашигтай ашиглалтын болон их засвар хийж, Цагдаагийн газрын барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засварийг цаг тухайд нь хийлгэж зөрчил дутагдалгүй ажилласан. Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасны дагуу хувийн хэрэг хөтлөн ажилласан.

Эрсдэл бүхий объект, автомашины судалгааг гаргаж даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулан байгууллагын төв контор, эрсдэлтэй авто тээврийн хэрэгсэлийг хөрөнгийн даатгалд хамруулж, алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулж ажилласан байна.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд -Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байдал /Код-110/

-Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2018 оны “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний журам /код 110/- ын 110.4, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын 89 дүгээр тогтоолын баталсан журмын 3 дугаар, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг журмын 6 дугаар, Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн биелэлтийг журмын 5 дугаар, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг журмын 11 дүгээр хавсралт, Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалтыг бүх шатны дарга, ахлах албан тушаалтануудад хариуцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Цагдаагийн газраас Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Захиргааны хэм хэмжээний акт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёр дахь хөтөлбөр, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний 2 дахь хөтөлбөр, Гэрч хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөр, Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүүхдийн хөгжил,

хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2019/, 2018 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019/, Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүний эрхийн үндэсний комисс, ЦЕГ-ын даргын хооронд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/46-р тушаалыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар, өгсөн үүрэг, ажлын чиглэл, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, баталсан хөтөлбөр, төлөвлөгөө, өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, тушаал шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтүүдийг заасан хугацаанд тухай бүр нь хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны “сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг 2018 онд хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 23- ны өдрийн 34/01-488 тоот албан бичгээр, 2018 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 34/01-568 тоот албан бичгээр тус тус холбогдох газарт хүргүүлж ажилласан.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 187 тоот тогтоолоор баталсан Ерөнхий менежер, нэгжийн менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын дагуу Цагдаагийн газрын даргатай бүх шатны дарга нар 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, тасгууд үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавин сар бүр ажлаа дүнгүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 48, 2009 оны 12 дугаар сарын 15-ны 188-р тогтоолоор батлагдсан заавар, журмын дагуу цагдаагийн газрын алба хаагч нартай тасгийн дарга нар 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, 2018 онд хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг нь батлан, хэрэгжилтэнд нь хяналт тавин сар бүр ажлыг нь дүгнэн үр дүнгээр нь цалинг олгон ажилласан.

-Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар

Тус цагдаагийн газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаартай тушаалаар эрсдлийн удирдлага, үнэлгээний тогтолцоог нэгтгэж зохион байгуулах орон тооны бус багийг томилуулсан.

Эрсдэлийн үнэлгээний багаас 2018 онд **нийт 4 бүлэг 4 заалт бүхий эрсдэл бүртгэж** алба хаагчдад учирч болох бүхий л эрсдлийг саармагжуулах, арилгах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Г.БОЛДБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА З.ГОМБО

